

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

2017
ЖИЛИЙН ТАЙЛАН

01

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

ЭРХЭМ ЗОРИЛГО
Түүхэн товчоон
Бидний баримтлал
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН
ЗАХИДАЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ
Тоон үзүүлэлтүүд
Татвар төлөлт

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СТРАТЕГИ БА БИЗНЕСТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ
Дахин зохион байгуулалт
Үнэ цэнийг бүтээх
Процессын сайжруулалт
БИЗНЕСИЙН ӨӨРЧЛӨЛТ ХЭРХЭН ХИЙГДСЭН БЭ?
Тусгаарлалт
Нэгдэл
ЗАХ ЗЭЭЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ
Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл
Архины зах зээл
Шар айрагны зах зээл
Ус, ундаа, шүүсний зах зээл
ҮЙЛ АЖИЛЛАГАА
Үнэ цэнийн гинжин хэлхээ
Бизнес нэгжүүдийн танилцуулга
Чанарын бодлого
ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД
2017 онд шинээр гарсан брэндүүд
2017 онд шинэчилсэн брэндүүд
ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД

03

ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
Ерөнхий мэдээлэл
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц
2017 оны онцлох үйл явдал
Охин компаниудын мэдээлэл
Компанийн хувьцаа эзэмшигчдийн зураглал
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ
2017 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баг
2018 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баг
ШИЙДВЭР ГАРГАХ ПРОЦЕСС
Их хэмжээний хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл
ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО
ХУВЬЦАА
Хувьцааны мэдээлэл
Ногдол ашгийн бодлого
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ
2017 онд томилогдон ажилласан Гүйцэтгэх
удирдлагын баг
2018 онд шинээр томилогдсон Гүйцэтгэх
удирдлагын баг
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА
Эрсдэлийн удирдлагын бодлого
Эрсдэлийн профиль
Эрсдэлийн зураглал
2018 оны өндөр эрсдэлүүд
ШАГНАЛ

04

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО
Тогтвортой хөгжил
Нийгмийн хариуцлагын хүрээнд бид

05

ТАЙЛАГНАЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН
Санхүү байдлын тайлан
Дэлгэрэнгүй орлогын тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан
ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн
бодлогууд
ТАЙЛБАР ТОЛЬ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нийгэмд баялаг бүтээх тулгуур хүч нь болж, өөрсдийн гаргасан амжилтаараа хүн, байгаль дэлхий, ирээдүйдээ хувь нэмрээ оруулахад оршино.





БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

Бизнес эрхлэлт:

Бид бүх шатанд багаар ажиллан хамтран туурвиж, хүмүүсээ зоригжуулан дуудаж, урамшуулан тэтгэн, тэргүүлэгч болохын төлөө эрмэлзэнэ.

Ил тод байдал:

Ил тод байдлыг эрхэмлэн, хийж буй ажилдаа бусдыг татан оруулж, урамшуулахын тулд зорилгоо бүрэн таниулна.

Өвөрмөц байдал:

Бид тулгарсан сорилт бүрийг даван туулж, хамтран ажилладаг түншүүд, нийгэмдээ дэмжлэг үзүүлэх ухаалаг замуудыг эрэлхийлнэ.

Чин шударга байдал:

Бид хийж байгаа зүйлээ үнэнч шударга, ёс суртахууны сахилга баттай гүйцэтгэж, Монгол улсын байгалийн баялгийг хойч үедээ өвлүүлэн үлдээж, дээд зэргийн стандартуудыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нэвтрүүлж, цаашид улам хөгжүүлэхийн төлөө ажиллана.

ТҮҮХЭН ТОВЧООН

Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анхны шар айраг үйлдвэрлэж эхэлсэн.

1927

Хийжүүлсэн амтат ундаа, Жанчивлангийн рашаан савлах цехийг шинээр байгуулжээ.

1961

ЗХУ-ын тусламжтайгаар Архи, пивоны комбинатын барилга, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгаж, тохируулга, туршилтын ажлыг хийж, 1972.12.31-ний өдөр БНМАУ-ын Засгийн газрын актаар байнгын ашиглалтанд оруулжээ.

1972

Архи пивоны комбинат 1976 оноос эхлэн 5 жил дараалан Улсын тэргүүний үйлдвэрээр шалгарч, төрийн дээд шагнал "АЛТАН ГАДАС" одонгоор шагнуулжээ. Монгол хүн анх удаа сансарт ниссэн үйл явдалд зориулан дээд зэргийн "Болор" архийг хэрэглэгчдэдээ хүргэж эхэллээ.

1981

11 дүгээр сард Монгол Улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын салхийг хагалж, компанийн төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг дуудлага худалдаанд оруулснаар АПУ ХК хувийн өмчид бүрэн шилжив.

2001

1924

Монгол Ардын Намын Төв хорооны V хурал, Ардын засгийн газрын VII хурлаар "Архины онц эрхийг улсын санд авах тухай" дүрмийг баталжээ. Ийнхүү Улаанбаатар хотод 14 ажилтантай анхны архины үйлдвэр нээгджээ.

1958

Шар айрагны үйлдвэрт хөргөлт, даралтат хийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулж, цагт 3000 шил шар айраг савлах хүчин чадалтай механикжсан урсгал шугамыг ашиглалтанд оруулан, техник технологийн дэвшилт хийв.

1971

Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг сайн зохион байгуулж, оногдсон үүргээ амжилттай биелүүлсэн учир Архи пивоны төв үйлдвэрийг БНМАУ-ын Засгийн газрын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнажээ.

1973

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1973 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн 10-р тогтоолоор Архи пивоны төв үйлдвэрийг Улаанбаатарын Архи пивоны комбинат (АПК) гэж нэрлэхээр тогтов.

1992

Архи, пивоны комбинатыг АПУ ХК болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувийг төрийн мэдэлд үлдээж, 49 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалсан.

Ус, ундааны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 4.5 – 5.0 сая литр бүтээгдэхүүнийг 0.33 л, 0.5 л, 1.5 л, 2 л-ийн хуванцар саванд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. "APU Цэвэр ус"-ны брэндийг хэрэглэгчдийн гарт хүргэлээ.

2004

Хоногт 15.0 мянган литр тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх хүчин чадалтай, Герман улсын техник, технологиор тоноглогдсон компьютерийн хяналт удирдлагатай, орчин үеийн Спиртийн шинэ үйлдвэр "Натур-Агро"-г улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулжээ. Залуусын брэнд "Fusion" шар айраг болон хүүхэд залуусын уух дуртай "Фрутта" жимсний шүүсийг зах зээлд нэвтрүүлэв.

2009

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах тоног төхөөрөмжөөр дэлхийд тэргүүлдэг Германы ГИА (GEA) компанитай хамтран сүүний шинэ үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулав.

2014

БИЗНЕСИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТ ТУСГААРЛАЛТ:

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг АПУ ХК-аас тусгаарлаж, АПУ Дэйри ХХК гэх охин компанидаа энэхүү эрх, үүргээ шилжүүлж, 2017 оны 09-р сарын 22-ны өдөр АПУ Дэйри ХХК-ийг үүсгэн байгуулсныг бүртгүүлсэн

НЭГДЭЛ:

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 224 тоот "АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай" тогтоолоор АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, хаалттай хүрээнд Хайнекен Азия Пасифик Пте.Лтд-д 266,091,981 ширхэг, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК-д 55,212,572 ширхгийг тус тус эзэмшүүлэхийг зөвшөөрсөн.

2017

2003

Шар айрагны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 20.0 сая литр шар айргийг шил болон ган торхонд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулав. Монголын анхны шилтэй хар пиво "Хар Хорум" болон дээд зэрэглэлийн "Алтан Говь" шар айраг худалдаанд гарлаа. "Ерөөл" брэндийг зах зээлд гаргав.

2006

АПУ ХК сүү, жимсний шүүсний үйлдвэрийг байгуулжээ. Мөн Тетра-Пак бүрэн автоматжсан шугамын хамт "Цэвэр Сүү" брэндийг хэрэглэгчдэд танилцуулсан.

2013

Шингэн хүнсний салбарт шинэ технологи, стандартыг нэвтрүүлсэн шар айрагны шинэ үйлдвэрийг, агуулахын стандартад дэвшилт гаргасан бүрэн автомат "АПУ Ложистик" төвийг тус тус бүтээн байгуулав. "Оргилуун" хийжүүлсэн усны брэндийг анх удаа Монголын зах зээлд нэвтрүүлсэн. Монголчуудын эртний танил "Боргио" шар айраг бүрэн шинэчлэгдэв.

2016

"Шинэ давалгаа"-г зах зээлд нэвтрүүлэх зорилтын хүрээнд Bliss жимстэй, бага градустай шар айраг, VELVET, EDEN, ARKHI EXPORT /40 жил/, Тайга /4 төрөл/, Охь зэрэг брэндүүдийг зах зээлд шинээр нэвтрүүлэв.

БИДНИЙ БАРИМТЛАЛ

ТӨГС, ТӨГӨЛДӨР, ТУНГАЛАГ

Absolute, Pure, Unique

Монголын уламжлалт нүүдэлчдийн соёл, гүн ухаанд хурмаст тэнгэрийг цэвэр хязгааргүйн билэгдэл, хөвчин дэлхийн онгон байгалийг цаг хугацаа, оюун ухааны хосгүй нэгдэл гэж үздэг. Энэ хоёр ижилгүй шинж нийлэн цэвэр ариун чанарыг он удаан жил хадгалж иржээ. “Төгс, Төгөлдөр, Тунгалаг” гурвалыг “Хамгийн Шилдэг”-ээ дээдлэх Монгол уламжлалаар “Дээж” болгон өргөн барьж байна. Энэхүү итгэлийг бид бизнесийнхээ цөм болгон, хийж байгаа бүхнээ улам сайжруулахыг эрмэлздэг. Бидний хөрөнгө оруулалтаар боссон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бид үйлчлүүлэгч нартаа болон нийгэмдээ зориулан цаг үргэлж боловсронгуй болгохоор ажиллах болно.



ТӨГС

Үүрэг хариуцлага

- Бид хөгжлийг хөтөлж, нийгмийг манлайлан, зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулна.
- Компанийн санхүү, мэдээллийг ил тод, үйл ажиллагааг тогтвортой байлгана.
- Монголын тэргүүлэгч ажил олгогч байна.

ТӨГӨЛДӨР

Соёл, бүтээгдэхүүн

- Орчин цагийн зах зээлийг манлайлан тодорхойлж, хүнсний монгол брэндийг бүтээн үйлдвэрлэгч байна.
- Дэлхийн түвшний бизнесийн байгууллагуудтай түншилж, хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монголын хэл, соёлын өвөрмөц өвийг хадгалан хамгаалж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ТУНГАЛАГ

Ёс зүй, орон зай

- Бид хүн, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, үнэт зүйлээ дээдэлнэ.
- Компанийн хөгжил нь үйлдвэрлэлийн шинэ технологи дээр суурилна.
- Бизнесийн ил тод байдал, аюулгүйн нөхцөлийг хангаж ажиллана.



АПУ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн Дарга

Пүрэвийн БАТСАЙХАН

Хүндэт хувьцаа
эзэмшигч Та
бүхэндээ энэ
өдрийн мэндийг
хүргэе!

Улиран одож буй 2017 он бидний хувьд онцгой дурсамжтай, түүхэн жил болж өнгөрлөө. Бид 2007 онд анх санаачлан эхлүүлж, 2014 онд 45.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх замаар зах зээлд шинэ өнгө төрх, шилдэг брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхэлсэн сүүний бизнесээ цар хүрээг нь улам өргөжүүлэх зорилгоор "өрх тусгаарлан", үйл ажиллагааг нь охин компанийн бүтцэд шилжүүлсэн бөгөөд өдгөө АПУ Дэйри ХХК зах зээл дээрх 2 дахь том тоглогч болжээ. Энэхүү охин компани маань ирээдүйд үйл ажиллагаагаа улам тэлж, Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын хөгжлийг шинэ шатанд гаргана гэдэгт миний хувьд итгэл төгс байна.

2017 онд бидний түүхэнд үлдэх өөр нэгэн "онцлох үйл явдал" болсон нь АПУ ХК-д Хайнекен компанийн хөрөнгө оруулалттай компаниудыг нэгтгэсэн явдал байлаа. Энэхүү нэгдлийн үр дүнд Монголын хөрөнгийн биржийн зах зээлийн нийт үнэлгээний даруй дөрөвний нэгээс илүүг бүрдүүлэгч компани бий болсон нь Та бидний бахархах амжилт юм.

2018 оны хувьд бид өсөлт, тэлэлтийн шинэ чиглэл, хөгжлийг цогцлоох шинэ хөдөлгүүрийг тасралтгүй эрэлхийлэх хүчин чармайлтаа улам идэвхжүүлнэ. Нэгдлийн үр дүнд үүссэн синергийн боломжуудыг тодорхойлон, ашигт ажиллагаагаа сайжруулахын зэрэгцээ гадаад зах зээл рүү чиглэсэн бизнесийн хөгжлийн далайцыг дахин шинэ шатанд гаргахаар ажиллаж байна.

Бидний дэргэд ОХУ болон БНХАУ-ын үлэмж том зах зээл, хязгааргүй их боломж байна. Тэртээ 13-р зуунд Монголын Их Эзэнт Гүрний нөлөөгөөр архи нэрэх технологи анх Еврази тивээр тархаж, Хубилай хааны байгуулсан Юань гүрний үед уламжлалт хятад архины технологид даралттай уур ашиглах аргыг Монголчууд нэвтрүүлж байсан баялаг түүхээс бид урам зориг авч, урагшаа тэмүүлэх болно.

"Бид хамгийн сонирхолтой, түүхэн цаг үеийг хамтдаа туулж, дэлхийд данстай компанийг хамтдаа бүтээнэ".

НЭГ ГЭР БҮЛ, НЭГ ЗОРИЛГО.



АПУ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

АПУ ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

**Эрхэм хүндэт
хувьцаа
эзэмшигч,
хөрөнгө
оруулагч,
харилцагч та
бүхэнд энэ
өдрийн мэндийг
хүргэе!**

Цахилан одох цаг хугацаа урсан өнгөрч, аль хэдийнээ нэг жилийг ардаа үдэж, өнгөрсөн бүхэн бидэнд туршлага, мэдлэгийг үлдээж өнөөдөртэй золгожээ. Яг энэ цаг мөчид Монгол улсын шингэн хүнсний хөгжлийг тодорхойлогч АПУ ХК-ийн 2017 онд гүйцэтгэсэн ажлын тайлан маань та бүхэнд хүрч байгаад баяртай байна.

Өнгөрсөн 2017 онд 94 жилийн туршлагатай АПУ ХК нь өөрсдийн бүтээсэн бат суурин дээрээ олон улсын зах зээлд компанийн бүтээгдэхүүнийг таниулах, дэлхийн брэнд үйлдвэрлэгчдийн арга туршлагыг нэвтрүүлэх зорилгоор дэлхийн шар айрагын зах зээлд тэргүүлэгчдийн нэг Хайнэкэн компанитай олон жилийн турш хэлэлцсэний үр дүнд Монгол дахь эзэмшлийн компаниудыг нэгтгэх замаар шинэ бүрэлдэхүүн, шинэ зохион байгуулалттайгаар үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж, шингэн хүнсний салбарт нэгэн түүхийг бичсэн онцлогтой жил байлаа.

Энэхүү түүхэн нэгдлийн үр дүнд АПУ ХК-ийн хувьцаа урьд нь байгаагүй дээд хэмжээнд хүрч, Монголын Хөрөнгийн бирж дээрх хамгийн үнэ цэнэтэй хувьцаагаар нэрлэгдсэн юм. Бидний хувьд нэгдлийн үе шат бүхэнд онцгой анхаарч ажилчдынхаа өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан цомхтгол огт хийлгүйгээр, амжилттай нэгдэх үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2017 онд нийт 921 ажилчидтайгаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирснийг энд цохон тэмдэглэхийг хүсч байна.

Мөн сүү сүүн бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн сүүний бизнес нэгжийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар хүрээг

тэлэх зорилгоор АПУ Дэйри ХХК болгон бүтцийн өөрчлөлт хийж АПУ ХК-ийн охин компани болгон өрх тусгаарласан билээ.

Бидний хувьд 2017 онд нийт 166 нэр төрлийн 97,2 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, улсад 129.4 тэрбум төгрөгийн татвар төлж, 24,8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд энэхүү ашгаасаа хувьцаа эзэмшигчдэдээ хүртээхээр ТУЗ-ийн шийдвэр гарч улмаар 2018 оны 6 сард нэгж хувьцаанд 10 төгрөгийн ноогдол ашиг тараахаар боллоо. Түүнчлэн олон улсын банк санхүүгийн байгууллагад 43,9 тэрбумын зээлийн хүүгийн эргэн төлөлт гүйцэтгэж, үйлдвэрлэлдээ 3,5 тэрбумын хөрөнгө оруулалт хийжээ.

2018 онд нэгдсэн АПУ ХК-ийн хувьд нийт 218 нэр төрлийн 133,7 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 433,7 тэрбумын борлуулалт хийхээр төлөвлөөд байна. Экспортын хувьд ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Япон, БНСУ зэрэг орнууд руу бүтээгдэхүүнээ худалдаалж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Бид Нэг Гэр бүл” гэсэн уриан дор төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд өв соёл, байгаль орчин, хүний хөгжилд оруулах хөрөнгө оруулалтуудыг мөн үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна.

Та бүхэн бидний нэг эд эс байж, хөгжлийн түүхэн жилд нэг сэтгэл зүрхтэйгээр хамт цохилж, нэгдмэл хүчээр хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

ХАМТДАА ИЛҮҮ ХҮЧТЭЙ




2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


Цэвэр борлуулалтын орлого
(тэрбум төгрөг)

5%




Үйл ажиллагааны ашиг
(тэрбум төгрөг)

8%




Цэвэр ашиг
(тэрбум төгрөг)

8 Дахин




Борлуулалтын тоо хэмжээ
(сая.литр)

12%




Бүтээгдэхүүний нэр төрөл
(SKU)

1%



Нийт ажилчдын тоо

13%



ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		Аудитлагдаагүй	Аудтлагдсан	Өөрчлөлтийн %
		нэгтгэсэн	нэгтгэсэн	
		санхүүгийн тайлан	санхүүгийн тайлан	
		2017	2016	
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭ				
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	97,229	93,137	4%
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	234,606	208,653	12%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	39,208	36,325	8%
Цэвэр ашиг	сая.төг	24,872	3,019	
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	172,185	90,554	90%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	460,730	200,389	130%
Нийт хөрөнгө	сая.төг	632,914	290,943	118%
Нийт өр төлбөр	сая.төг	125,989	148,270	-15%
Нийт эздийн өмч	сая.төг	506,926	142,672	255%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	632,914	290,943	118%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	41,779	47,853	-13%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(3,576)	(2,965)	21%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(32,834)	(35,132)	-7%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	5,369	9,756	-45%
ТАТВАР ТӨЛӨЛТ				
Онцгой албан татвар	сая.төг	95,030	90,420	5%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	20,713	19,119	8%
Бусад	сая.төг	13,621	17,422	-22%
Нийт	сая.төг	129,364	126,961	2%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	4,748	2,977	60%

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн нэгдлийн өдрийг 2017.12.31-р тооцсон. Тайлагналын зарчим хэсгээс дэлгэрэнгүйг харна уу. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг 2018 оны 05-р сард авахаар төлөвлөн ажиллаж байна. 2016 оны тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланд АПУ ХК, Гранд ХХК-н үр дүн орсон болно.

ТАТВАР ТӨЛӨЛТ


APU company-н 2017 оны татвар төлөлт нь Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6%, татварын орлогын 2.1%, онцгой албан татварын орлогын 18.3%, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 1.3%-ийг дангаар бүрдүүлэн ажилласан байна.



Монгол улсын нэгдсэн
төсвийн орлого



Нэмэгдсэн өртгийн албан
татварын орлого



Онцгой албан
татварын орлого



APU COMPANY-Н 2017 ОНД МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН НИЙТ ТАТВАРЫН ОРЛОГООР ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол улсын нэгдсэн төсөв 2018

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



СТРАТЕГИ БА БИЗНЕСТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Бид 2017 онд компанийн хэмжээнд дараах нэн тэргүүний асуудлуудыг дэвшүүлж ажилласан.

PEOPLE/ RESTRUCTURING

Корпорацийн бизнесийн портфолиог тогтвортой, өндөр үнэ цэнэ бий болгохуйцаар дахин зохион байгуулах
Нэгдлийн үйл ажиллагааг удирдах мастер төлөвлөгөө боловсруулах

VALUE CREATION

Гол үнэ цэнэ бий болгох боломж, санаачлагыг хэрэгжүүлэх,
Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
Синергийн нөлөөг тооцох мастер төлөвлөгөө боловсруулах

PROCESS

Компанид үнэ цэнэ бүтээж буй үйл ажиллагаанд төвлөрөх
Нэгдэлтэй холбоотой үйл ажиллагааны процессыг нэгтгэх мастер төлөвлөгөө боловсруулах

ДАХИН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


ТУСГААРЛАЛТ

Бид 2017 онд АПУ ХК-аас Сүүний бизнесийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулалт хийж, шинээр охин компани АПУ Дэйри ХХК-г дараах үндэслэлээр үүсгэн байгууллаа.


- АПУ ХК-н дунд болон урт хугацааны стратегийн зорилгын хүрээнд тусгагдсаны дагуу сүүний бизнес нэгжийг бие даасан ашгийн төв болгох
- Хөрөнгө оруулагчдад компанийн бизнес бүрийн үнэ цэнийг үнэлэхэд илүү тодорхой болгох
- Сүүний бизнес нэгжид стратегийн түншлэлийг бий болгох суурь тавигдах
- Хэрэглэгчдэд чанартай, шинэ бүтээгдэхүүнийг шуурхай хүргэхийн тулд сүү бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын хэлхээний нэгдсэн удирдлагын тогтолцоог бий болгох

Бид бизнес портфолийн бүтэц, бизнес нэгж хооронд үүсэх синергийг хамгийн өндөр байлгах зорилго тавин охин компанийг тусгаарлах компанийн бизнес нэгжийн портфолийн бүтцийн зохион байгуулалтыг дараах хэлбэрээр өөрчлөн байгууллаа.

ТУСГААРЛАХААС ӨМНӨХ БИЗНЕСИЙН НЭГЖИЙН ПОРТФОЛИЙН БҮТЭЦ



ТУСГААРЛАСНЫ ДАРААХ БИЗНЕСИЙН НЭГЖИЙН ПОРТФОЛИЙН БҮТЭЦ



НЭГДЭЛ

Бид 2017 онд АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-г нэгтгэх замаар өөрчлөн байгуулалт хийв. Энэхүү томоохон нэгдлийн дүнд хоёр компанийн хөрөнгө, нөөц боломжийг хамгийн зохистой байдлаар нэгтгэж, шингэн хүнсний салбарт шинэ үнэ цэнийг бий болгох үндэс суурийг тавилаа. Бид нэгдлийн үйл ажиллагааг дараах 5 эрхэм зорилгыг чиглэл болгон хэрэгжүүлж байна.

Нэгдлийн эрхэм зорилго

- ✓ Монгол улсдаа манлайлагчийн байр сууриа хадгалах, бэхжүүлэх
- ✓ Нэгдлийн синергийг хамгийн их байлгах
- ✓ Олон улсын стандартын зохион байгуулалт, засаглалыг цогцлоох
- ✓ Нийгмийн хариуцлага ба тогтвортой байдлыг үргэлжлүүлэн дэмжин ажиллах
- ✓ Монгол улсаас гадагш олон улсын зах зээлд нэвтрэх, импортыг орлуулах

Нэгдлийн үр дүн



Дэлхийн түвшний стратегийн хөрөнгө оруулагч, түнштэй (HEINEKEN) болсноор үйл ажиллагаа, компанийн засаглалыг хөгжлийн шинэ шатанд гаргана.



АПУ ХК Монгол улсын шингэн хүнсний тэргүүлэгч компани, бүс нутгийн болон Олон Улсын зах зээлийн тоглогч болно.

Хувьцаа эзэмшигч, харилцагч, хэрэглэгч, компанийн хамт олонд өндөр ач холбогдол бүхий үнэ цэнийг бий болгоно.

Татвар төлөлт, нийгмийн хариуцлагын хэрэгжилтээр тэргүүлэгч байр сууриа бататган, дотоодын эдийн засагт оруулах хувь нэмрээ нэмэгдүүлнэ.

ҮНЭ ЦЭНИЙГ БҮТЭЭХ



ПРОЦЕССЫН САЙЖРУУЛАЛТ

Бид 2017 онд “Бизнес процессыг стандартчилах” зорилгынхоо хүрээнд одоогийн бизнес процессыг сайжруулж, цаашид стандартчилах, хүнд төвлөрсөн, хүнээс хамааралтай байдлыг бууруулах зорилт тавин дараах стратегиудыг баримтлан ажиллаж бодитой үр дүнд хүрлээ.

Процесс дээр суурилсан удирдлагын тогтолцоо бүхий оновчтой орон тоо бүтэц зохион байгуулалттайгаар, бага цаг хугацаа зарцуулж, өндөр бүтээмжтэй, зардал багатай үйлдвэрлэлийн нэгдсэн систем нэвтрүүлэх стратеги.



Компанид үнэ цэнэ бүтээж буй үйл ажиллагаанд байнгын сайжруулалт хийж, үнэ цэнийг нэмэгдүүлж, цэвэр ус болон эрчим хүчний зарцуулалтын хэмжээг бууруулан, үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглан ажиллах стратеги.

БИЗНЕСИЙН ӨӨРЧЛӨЛТ ХЭРХЭН ХИЙГДСЭН БЭ?

ТУСГААРЛАЛТ

Тусгаарлах ажиллагааны ач холбогдол:

- Сүүний бизнесийн онцлогт тохирсон шийдвэр гаргалт, засаглалын тогтолцоог нэвтрүүлнэ.
- Сүү хүлээн авахаас эхлэн борлуулалт хүртлэх Үнэ цэнийн гинжин хэлхээ буюу VALUE CHAIN-ийг илүү үр ашигтай удирдах нөхцөл бүрдэнэ.
- Сүүний бизнес нэгжийн дунд болон урт хугацааны стратегийн зорилгод хүрэх суурь тавигдана.
- Сүүний салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулагч томоохон тоглогч болно.

Үйл явдлын хураангуй:

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг АПУ ХК-аас тусгаарлаж, АПУ Дэйри ХХК гэх охин компанидаа энэхүү эрх, үүргээ шилжүүлж, 2017 оны 09 дүгээр сарын 22-нд улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

Нэр: АПУ Дэйри ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011696053

Регистрийн дугаар: 6229654

Албан ёсны хаяг: Хан-Уул дүүрэг, 1- хороо, Чингисийн өргөн чөлөө, 33/5 тоот

Үйл ажиллагааны чиглэл: сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жүүс ундаа үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, гадаад худалдаа

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: 54,619,000,000 төгрөг
Хувьцаа эзэмшигч: АПУ ХК – 100% (Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг АПУ ХК-ийн ТУЗ хэрэгжүүлэх зөвшөөрлийг АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас олгосон)

Төлөөлөн удирдах зөвлөл: байхгүй

Гүйцэтгэх захирал: Г.Энхбилэг

ЦАГ ХУГАЦААНЫ ХҮСНЭГТ

2017.07.20

"АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, тусгаарлах нөхцөл, журмын төслийг батлах" тухай ТУЗ-ийн хурлын тогтоол гарсан.

2017.07.06

"Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг товлон зарлаж тусгаарлах асуудлыг хэлэлцэх асуудлаар оруулах" тухай ТУЗ-ийн хурлын тогтоол гарсан.

2017.08.18

"АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрч, ТУЗ-д эрх олгох" тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол гарсан.

2017.08.21

АПУ Дэйри ХХК-ийг үүсгэн байгуулах, түүний Дүрмийг баталж, Гүйцэтгэх захирлыг томилох тухай ТУЗ-ийн хурлын тогтоол гарсан.

Хувьцаат компани өөрчлөн байгуулагдах зөвшөөрлийг СЗХ-оос хүссэн.

2017.09.07

СЗХ-оос тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан.

2017.09.22

АПУ Дэйри ХХК-ийг үүсгэн байгуулсныг бүртгүүлсэн.

2017.09.30

АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсаныг харилцагчид, зээлдүүлэгчид, холбогдох төрийн байгууллагуудад мэгдэгдсэн.

НЭГДЭЛ

Нэгдлийн үр дүнд

Дэлхийн түвшний стратегийн хөрөнгө оруулагч, түнштэй (HEINEKEN) болсноор үйл ажиллагаа, компанийн засаглалыг хөгжлийн шинэ шатанд гаргана: HEINEKEN-н Глобал шар айрагны ноухау-г нэвтрүүлж, хэрэглэгчдэд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн шилдэгээр баяжуулна. Компанийн засаглалд олон улсын тэргүүний туршлагыг нэвтрүүлж, Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулна.

АПУ ХК Монгол улсын шингэн хүнсний тэргүүлэгч компани, бүс нутгийн болон олон улсын зах зээлийн тоглогч болно: Одоогийн бизнесийг газарзүйн бусад гол бүсүүд рүү тэлэх (Зүүн Өмнөд Ази, Европын Холбоо, Хойд Америк) ажиллагаа бодитоор хэрэгжиж, экспортын орлогыг дорвитой өсгөн, импортыг орлуулна.

Хувьцаа эзэмшигч, харилцагч, хэрэглэгч, компанийн хамт олонд өндөр ач холбогдол бүхий үнэ цэнийг бий болгоно:

- Үйлдвэрлэл, түгээлтийн сүлжээний далайцыг өргөжүүлж, Heineken-н олон улсын худалдан авалтын боломжийг ашиглан, үйлдвэрлэлийн өртөг, борлуулалт, удирдлагын зардлыг бууруулах замаар үйл ажиллагааны синерги бий болгож, ашиг орлогыг нэмэгдүүлэн, компанийн зах зээлийн үнэлгээг өсгөхийн зэрэгцээ ногдол ашгийн хуваарилалтыг нэмэгдүүлнэ.
- Хоёр компанийн давуу талуудыг хослуулан, маркетинг түгээлтийн үйлчилгээнд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлж, харилцагчдыг шилдэг бүтээгдэхүүн ба үйлчилгээгээр хангана.
- Хэрэглэгчдэд дээд зэргийн чанар, сонголт бүхий, гадаад дотоодын тэргүүлэх брэндээс бүрдсэн бүтээгдэхүүний багцыг санал болгон, хариуцлагатай хэрэглээг эрхэмлэн ажиллана.
- Ажлын байрны тогтвортой байдлыг хангаж, компанийн хамт олонд дэлхийн дэвшилтэт технологи, үйл ажиллагаа, засаглалын шилдэг туршлагаас суралцан, хувь хүний хөгжилд үсрэнгүй ахиц дэвшил гаргах боломжийг олгоно.

Татвар төлөлт, нийгмийн хариуцлагын хэрэгжилтээр тэргүүлэгч байр сууриа бататган, дотоодын эдийн засагт оруулах хувь нэмрээ нэмэгдүүлнэ: Улсын төсөвт төлөх татварын хэмжээг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах замаар олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх үйл хэрэгт хувь нэмэр оруулна.

Үйл явдлын хураангуй

Нэгтгэсэн компани: АПУ ХК
Нэгдсэн компани: Эвэргрийн Инвестментс ХХК

Нэгтгэхтэй холбогдуулан АПУ ХК-аас нэмж гаргасан хувьцааны мэдээлэл:

- Хувьцааны төрөл: энгийн;
- Хувьцааны тоо ширхэг: 321,304,553;
- Зориулалт: Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигч болох Хайнекен Азия Пасифик Пте.Лтд, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нарт хаалттай хүрээнд эзэмшүүлэх.

Нэмж гаргасан хувьцааны төлбөрт доорх компаниудын хувьцааг авсан:

1. Сингапур Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд
2. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Спирт бал бурам ХХК ГХО
3. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан СББ Трейд ХХК ГХО
4. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК ГХО
5. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан АПУ Трейдинг ХХК,
6. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Улаанбаатар спирт ХХК,
7. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Депод ХХК,
8. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Натур агро ХХК

Нэгтгэх гэрээ:

Доор заасан Компанийн тухай хуулийн заалтын дагуу энэхүү гэрээ нь их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарагдах тул холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэгдсэн болно.

- Нэгтгэх гэрээний үнийн дүн нь өмнөх санхүүгийн жилийн эцсийн балансын дүнгийн 25%-аас дээш байгаа тул их хэмжээний хэлцэлд тооцогдсон.
- Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нь Шунхлай групп ХХК-ийн 100%-ийн охин компани тул сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдсон.

ЦАГ ХУГАЦААНЫ ХҮСНЭГТ

2017.07.0

“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг товлон зарлаж АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-г нэгтгэх, хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргах асуудлыг хэлэлцэх асуудлаар оруулах” тухай ТУЗ-ийн хурлын тогтоол гарсан.

2017.0.23

АПУ ХК нь Кредит Свисс банкттай 2013 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан зээлийн гэрээнд заасны дагуу АПУ-г нэгтгэх замаар өөрчлөн байгуулахад шаардлагатай зөвшөөрлийг авсан.

2017.10.13

АПУ ХК нь Европын сэргээн босголт хөгжлийн банкттай 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан зээлийн гэрээнд заасны дагуу АПУ-г нэгтгэх замаар өөрчлөн байгуулахад шаардлагатай зөвшөөрлийг авсан.

2017.11.2

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 224 тоот “АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай” тогтоолоор АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, хаалттай хүрээнд Хайнекен Азия Пасифик Пте.Лтд-д 266,091,981 ширхэг, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК-д 55,212,572 ширхэгийг тус тус эзэмшүүлэхийг зөвшөөрсөн.

2017.12.22

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт Эвэргрийн Инвестментс ХХК-ийг АПУ ХК-д нэгдэх замаар өөрчлөн байгуулагдан үйл ажиллагаагаа зогсоосныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлт гаргаж, 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр улсын бүртгэлээс хасуулж, АПУ ХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсаныг бүртгүүлсэн.

2017.0.1

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас “АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх, түүнтэй холбогдсон бусад хэлэлцсэн асуудлыг батлах” тухай тогтоол гарсан.

2017.0.2

Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэн Монголын хөрөнгийн биржид хүргүүлсэн.

2017.10.23

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/199 тоот тушаалаар АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

2017.11.30

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аас үнэт цаасны бүртгэлд оруулсан өөрчлөлтийг нэгдсэн мэдээллийн системд бүртгэж, Хайнекен Азия Пасифик Пте.Лтд-ийн дансанд 266,091,981 ширхэг энгийн хувьцааг, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК-ийн дансанд 55,212,572 ширхэг энгийн хувьцааг тус тус байршуулсан.

201.01.2

АПУ ХК-н Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг сонгосон бөгөөд Хувьцаа эзэмшигчдэд нэгтгэх ажиллагааны тайланг танилцуулсан.

ЗАХ ЗЭЭЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл

2017 онд Олон улсын зах зээлийн судалгааны “Евромонитор” компанийн гүйцэтгэсэн судалгаагаар дэлхийн сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл 443 тэрбум долларт хүрсэн бөгөөд 2022 он гэхэд зах зээл жилд дунджаар 2,8% өсч 494 тэрбумд хүрэх тооцоо гарчээ. Сүү, сүүн бүтээгдэхүүний категориудаас йогуртны зах зээл хамгийн өндөр буюу жилд дундажаар 5-6% өсөхөөр тооцоологдсон бол шингэн сүүний зах зээл жилд дунджаар 2% өсөх хандлагатай байна.

Монгол улсын хувьд 2017 онд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл 45.5 сая литрт хүрч, өмнөх оноос 7.1 хувиар өссөн. Энэхүү өсөлт нь Монгол хэрэглэгчдийн уламжлалт хэрэглээ үйлдвэрийн аргаар боловсруулсан бэлэн бүтээгдэхүүн рүү шилжиж байгаа хэрэглээний бүтцийн өөрчлөлт болон эдийн засгийн өсөлттэй холбоотой юм. Нийт зах зээл дэх үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүүний зах зээл 31.9 сая литр буюу өмнөх оноос 3.2 хувиар өссөн бол тараг, йогуртны зах зээл 13.6 сая литр буюу өмнөх оноос 17.2%-аар тус тус өсчээ. 2013 оноос хойш Монгол улсын зах зээл дэх импортын шингэн сүүний хэмжээ буурч, дотоодын үйлдвэрийн шингэн сүүний нийлүүлэлт 2017 оны байдлаар 99.9% -г бүрдүүлж байна.

2017 оны байдлаар АPU Company зах зээлд 4 брэндийн 39 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна.

Архины зах зээл

Эдийн засгийн нөхцөл байдал, хэрэглэгчдийн хэрэглээний шилжилт зэргээс хамааран дэлхий дахинд архины зах зээлийн өсөлт зогсонги байдалтай хэвээр байна.

2017 онд Монгол улсын архины зах зээл биет хэмжээгээр 27.47 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 2.4 хувиар өсч цаашид зах зээл өсөлтийн эерэг төлөв рүү шилжих төлөвтэй байна. Зах зээлийн 7% хямд үнэтэй архины сегмент, 63% дундаж үнэтэй архины сегмент, 30% үнэтэй болон хэт үнэтэй архины сегментүүд тус тус бүрдүүлж байна.

Монгол улсын эдийн засгийн байдал, иргэдийн худалдан авах чадвар, хэрэглээний хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой хэрэглэгчид дундаж үнэтэй архинаас илүүтэйгээр хямд эсвэл өндөр үнэтэй архи сонгон хэрэглэх байдал нэмэгдэх болсон. Хэрэглэгчдийн хэрэглээний ялгаралаас үүдэж үнэтэй брэндээс доош, дундажаас дээш түвшний сегментийн архины хэрэглээ буурах төлөвтэй байна.

АPU company нь 2017 оны байдлаар нийт 14 брэндийн 60 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн гаргаж байна.



Шар айрагны зах зээл



Дэлхийн хэмжээнд шар айрагны үйлдвэрлэл 1998-2013 оны хооронд өсөлт үзүүлж, 2013 оноос хойш тогтворжих хандлагатай байна. Харин Монгол улсын хэмжээнд тус зах зээл нь 2014 оноос хойш эдийн засгийн байдал, худалдан авах чадвар, хэрэглээний хандлагаас хамааран хумигдаж байна.

2017 онд Монгол улсын шар айрагны зах зээл биет хэмжээгээр 94.7 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 1.3% - аар буурсан. Нийт зах зээлийн 49% хямд үнэтэй шар айраг, 40% дундаж үнэтэй шар айраг, 11% үнэтэй шар айраг тус тус эзэлж байна.

Шар айрагны бүтээгдэхүүний хөгжүүлэлт, маркетинг ПР эрчимтэй хөгжиж дотоодын бүтээгдэхүүний чанар сайжрахын хэрээр гадны брэнд, импортлогчдод үлдэх орон зай багасаж 2017 оны байдлаар нийт зах зээлийн 5.3% - г импортын шар айраг эзэлж байна. Энэ нь 2016 онтой харьцуулахад -41.1%, 2013 онтой харьцуулахад -78.8% буурсан үзүүлэлт юм.

APU company нь 2017 оны байдлаар нийт 9 брэндийн 42 нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Ус, ундаа, шүүсний зах зээл



2017 онд Монгол Улсын хийжүүлсэн ундааны зах зээл биет хэмжээгээр 133 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад -1.9% буурсан бол савласан шүүсний зах зээл 16.6% өсч 68 сая литр, савласан усны зах зээл 13.3% өсч 74 сая литр хүрсэн.

APU company нь 2017 оны байдлаар нийт 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлж байгаа юм.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮНЭ ЦЭНИЙН ГИНЖИН ХЭЛХЭЭ

АПУ ОРЦ

САНХҮҮ

Хувь нийлүүлэгчдийн өмч, хөрөнгө, зээл тусламж, хөрөнгө оруулалт

ХҮМҮҮН КАПИТАЛ

Ажиллагсад, эрүүл аюулгүй байдал, ёс зүйн зарчим

НИЙГЭМ

Нийгмийн холбоо хамаарал

БАЙГАЛИЙН НӨӨЦ

Ус, энерги, газар, байгалийн бүтээгдэхүүн\

ҮЙЛДВЭРЛЭЛ

Барилга, үйлдвэрүүд, тоног төхөөрөмж

ОЮУНЫ КАПИТАЛ

Брэнд, судалгаа хөгжүүлэлт, инноваци, үйл ажиллагаа, компанийн нэр хүнд

2017 ОНЫ АПУ ГАРЦ

САНХҮҮ

- Цэвэр борлуулалтын орлого: **235 тэрбум** төгрөг
- ФНийт зарласан ногдол ашиг: **10.6 тэрбум** төгрөг

БАЙГАЛИЙН НӨӨЦ

- Саарал ус төсөл: **14 000 тонн**
- Цахилгааны хэмнэлт: **200 мянган кВт**

ХҮМҮҮН КАПИТАЛ

- Нийт ажиллагсад: **921**
- Хамтын гэрээний хэрэгжилт: **1.0 тэрбум** төгрөг
- Дотоод сургалтын тоо: **377**
- Бүтээгдэхүүний нэр төрөл: **164**

НИЙГЭМ

- "Тунгалаг Туул" аян
- "Save infant" төсөл

ШАГНАЛ

- ТОП 100 Аж Ахуйн Нэгж
- Red Dot Award
- Энтерпренер 2017
- Bloomberg Awards 2017- Шилдэг менежмент

БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

СҮҮНИЙ БИЗНЕС НЭГЖ, АПУ ДЭЙРИ ХХК

Сүүний бизнес нэгж нь 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн бие даасан аж ахуйн нэгж болон тусгаарлаж АПУ Дэйри ХХК нэрийн доор малчид фермерүүдээс сүү цуглуулахаас эхлэн хэрэглэгчид борлуулах хүртэл бүхий л үйл ажиллагааг нэгдсэн байдлаар явуулж эхлээд байна.

Анх 2014 онд фермийн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Ecolan савлах шугам, Япон улсын Elorak, EHEDG буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэр юм. 2017 онд нэмэлтээр аарц, цөцгийн тос боловсруулан, савлах тоног төхөөрөмжийг суурилуулсанаар Монгол үнээний сүүгээр үйлдвэрлэсэн цэвэр аарц, ааруул, цөцгийн тосыг хэрэглэгчиддээ шинэээр нь хүргэх боломжтой болсон.

Жилд 45 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай сүүний үйлдвэрийн боловсруулах хэсэг нь өдөрт 150 тонн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай.

Сүү бэлтгэн нийлүүлэлтийн тоо хэмжээ болон бүс нутгийг тасралтгүй өргөжүүлэн ажиллаж байна. 2017 онд 1200 гаруй малчид, фермерээс өдөр тутам өөрсдийн машин болон сүү цуглуулах цэгүүдээр дамжуулан сүү татан авч байна. Сүү хүлээн авах нутаг дэвсгэрийг өргөтгөж Сэлэнгэ аймгийн Мандал суманд шингэн сүү цуглуулах хөргөлтийн цэгийг нээлээ.

Малчид фермерүүдийн чадавхийг сайжруулах, чанартай сүү бэлтгэн нийлүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлээ. Тухайлбал, тэжээл бэлтгэлийн хугацаанд богино хугацааны санхүүжилт олгох, сүүний чанарыг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулах, малчид фермерүүдийн жилийн уулзалтыг зохион байгуулж, шилдэг туршлага, менежментийг нэвтрүүлсэн малчид фермүүдийг шагнаж урамшууллаа.

Олон Улсын Хүнсний Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцоо ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн манай үйлдвэр нь жил бүр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар стандартын хэрэгжилтээ баталгаажуулан, байнгын сайжруулалт хийн амжилттай ажиллаж байна. Мөн 2017 онд Улсын итгэмжлэгдсэн лабораторийн баталгаажуулалтын 17025-ын шаардлага, стандартыг бүрэн хангаж, итгэмжлэлийн гэрээгээ 3 жилээр сунгаж баталгаажууллаа.

АРХИ, СПИРТИЙН БИЗНЕС НЭГЖ

2017 онд:

- Натур Агро спиртийн үйлдвэр нь 2009 онд ашиглалтанд орсон бөгөөд Германы орчин үеийн дэвшилтэт технологи бүхий автомат тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.
- Архины үйлдвэр нь 1972 оноос эхлэн ашиглалтанд орсон бөгөөд Герман, Австри, Итали, улсын шилдэг фирмүүдийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютер микропроцессын хяналтын удирдлага бүхий үйлдвэр юм.

2018 онд:

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэнээр дээрх үйлдвэрүүдээс гадна доор дурьдсан үйлдвэр, нэгжүүдтэйгээр ажиллахаар төлөвлөөд байна.

- Улаанбаатар спирт ХХК нь 2002 онд ашиглалтанд орсон бөгөөд Германы үйлдвэрлэгч Шмидт компанийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
- Спирт Бал Бурам ХХК нь 1973 онд ашиглалтанд орсон. Хүнсний ууган үйлдвэрүүдийн нэг болох Спирт Бал Бурам ХХК нь 2009 онд хувьчлагдсан бөгөөд архины зах зээлийн хүчтэй тоглогчдын нэг юм.

ШАР АЙРАГНЫ БИЗНЕС НЭГЖ

2017 онд:

- Шар айрагны үйлдвэр нь 1927 онд Чех улсын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор сууриа тавьж байсан бол 2002 болон 2013 онуудад Германы Кронес компанийн хамгийн орчин үеийн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн шаардлагыг бүрэн хангасан техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдон бүрэн шинэчлэл хийснээр Германы тэргүүлэх 5 үйлдвэртэй ижил түвшинд хүрсэн томоохон үйлдвэр болсон байна.

2018 онд:

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэнээр дээрх үйлдвэрүүдээс гадна доор дурьдсан үйлдвэр, нэгжүүдтэйгээр ажиллахаар төлөвлөөд байна.

- М-Си-Эс Азия Пасифик Брюэри ХХК нь 2005 онд ашиглалтанд орсон бөгөөд дэлхийд шар айрагны үйлдвэрлэлээр тэргүүлэгч компани болох Хайнекеней чанар, стандартын шаардлагын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг томоохон үйлдвэр юм.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ БИЗНЕС НЭГЖ

2017 онд:

- АРУ Компани нь 2004 онд Ус Ундааны үйлдвэрийг бүрмөсөн шинэчлэх анхны төслийн ажлыг хэрэгжүүлэн Европын Холбооны эрүүл ахуйн шаардлага бүрэн хангасан дэлхийн нэртэй фирмүүд болох Австрийн "Клингер", Германы "Косме", "Гернеп", "Фамикс", Италийн "Самса Пак" зэрэг бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
- 2012 онд шинэ ПЭТ савлах шугамын төслийг Герман улсын KRONES компанитай хамтран хэрэгжүүлсэнээр үйлдвэрийн хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлсэн.



ЧАНАРЫН БОДЛОГО

БИД ЧАНАРЫН БОДЛОГОДОО ДАРААХ 4 ЗАРЧМЫГ БАРИМТЛАНА

- Хууль эрхзүйн болон хэрэглэгчийн шаардлагад бүрэн нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг 100% хангасан, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Хүнсний үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд FSSC22000: 2010, ISO 9001:2008 стандартуудын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, байнгын сайжруулалтыг хангана.
- Хүний нөөцийн хөгжил, техник, технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж шингэн хүнс үйлдвэрлэлийн манлайлагч компани болно.
- Хүнсний аюулгүй байдал болон чанарын удирдлагын тогтолцоонд гадаад, дотоод аудитын шалгалт хийх замаар үр дүнг баталгаажуулж ажиллана.

ЧАНАРЫН УДИРДЛАГА

APU Company нь ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм. Чанарын удирдлага, хяналтын алба нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процессд сорилт, шинжилгээ, туршилт, чанарын хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн байнгын мониторингийн хяналт тавьж ажилладаг.

Бидний бусдаас ялгарах талууд бол:

- Олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлсэн
- Хүнсний аюулгүй байдал, технологийн мэргэшсэн багуудтай
- Чанарын удирдлагын нэгдсэн систем бий болгосон
- Хууль, эрхзүйн нийцлийг бүрэн хангасан
- Процесст суурилсан чанарын мониторингийн хяналтыг бүрдүүлсэн

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Итгэмжлэгдсэн лаборатори нь олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүд болон ISO/IEC 17025 стандартыг мөрдлөг болгон APU Company -н үндсэн 5 үйлдвэрлэлд орж буй үндсэн болон туслах түүхий эд материал, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу мэдрэхүй эрхтний, микро биологийн, физик-химийн шинжилгээг үнэн зөв хийж, стандарт шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн гаргахад, технологийн дамжлага бүрт хяналт тавьж ажилладаг. Итгэмжлэгдсэн лабораториуд нь олон улсын сорилтын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO-17025:2007 стандартын шаардлагыг тогтмол хангаж ажилладаг ба Олон Улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, nano технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон.

Манай лабораториуд нь үйлдвэрлэлдээ дотоод хяналтыг тавихаас гадна үйл ажиллагааныхаа чиглэлээр Герман улсын VLB, Weihenstephan институт, ОХУ-ын Interlab, ФГБНУ ВНИИПБТ институт, Монгол улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиудтай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажилладаг судалгааны томоохон бааз юм. APU company-н дотоод хяналтын лаборатори нь дараах бодлогыг баримтална.

- Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоо болон сорилт шинжилгээний нэгдмэл байдлыг IEC/ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлж, байнгын сайжруулалтаар хангана
- Ажилтан ажиллагсдын хөгжил, техник технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ханган ажиллана
- Болзошгүй санхүүгийн болон бусад хүчин зүйлээс хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулна

ШИНЭ БОЛОН ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД

2017 ОНД ШИНЭЭР ГАРСАН БРЭНДҮҮД



КАЛТЕНБЕРГ СПЕЦИАЛ
(0.5л шил, 0.5л лааз, 5.6%)

Баварийн Хаадын удмын Калтенберг брэндийн шинэ гишүүн, Бавари мужийн баярын онцгой шар айраг болох Калтенберг Специал брэндийг 2017 онд зах зээлд нэвтрүүллээ. Баварын "Цэвэр Тунгалагийн Хууль"-ийн дагуу исгэсэн уг пиво нь Бавари мужийн Халлертау нутгийн сайн чанарын онцгой зөрөг цэцэг, дээд зэргийн арвайн соёлж, Калтенбергийн шалгарсан хөрөнгөөр исгэсэн шүүлтүүртэй цайвар пиво юм.



МААМУУ ГҮЗЭЭЛЗГЭНЭТЭЙ СҮҮ
(125мл)

Маамуу амтлаг сүүнүүд хүүхдийн дуртай гүзээлзгэний амтаар дахин нэр төрлөө нэмлээ. Гүзээлзгэний амттай Маамуу нь калциар баялаг тул өдрөөс өдөрт сэргэлэн цовоо хүүхдүүдийн өсөлтөнд онцгой ач холбогдолтой.



ДЭЭЖ ААРУУЛ
(400мл, 900мл)

Дээж ааруул жимстэй болон энгийн гэсэн 2 төрлөөр худалдаанд гаргасан. Агаар нэвтрүүлэх болон дахин ашиглах түгжээтэй уутан төрлийн савлагаанд савлаж гаргасан нь хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн болсон.



МААМУУ ЖҮҮС
(200мл)

Монгол орны хөрсөнд ургасан байгалийн аньс чацарганатай Маамууг Эрүүл Монгол хүүхдийн өдөр тутмын хэрэглээнд зориулан гаргалаа. А, С, В1, В2 аминдэм кали, кальци, магни, төмөр, иод зэргийг агуулсан нь биеийн эсэргүүцлийг дэмжих онцгой нөлөөтэй. Худалдаанд гарснаас хойш бяцхан хэрэглэгчдийн дуртай бүтээгдэхүүний нэг болсон билээ.



САЙН ИОГУРТ VEGGIE
(500мл)

Сайн брэнд 2017 онд Жимс, ногооны төгс хослол болох Сайн ногоо жимстэй йогурт зах зээлд гаргасан нь Монголын зах зээлд хамгийн анхны ногоо жимстэй йогурт болж чадсан. Амин дэм эрдсээр баялаг луван болон жүржтэй йогурт нь хүний биеийн дархлааг дэмжиж, өөх хайлуулан, арьсыг залуужуулна. Харин антиоксидантаар баялаг хүрэн манжин, алимны йогурт нь элэг цэвэрлэж, даралт тогтворжуулах давуу талтай.

2017 ОНД ШИНЭЧИЛСЭН БРЭНДҮҮД



БОЛОР
(750МЛ, 28%)

Монголд анх удаа бага калорийн агууламжтай, 28% -ийн алкоголийн агууламжтай Болор брэндийн төрлийг Олон Улсын тренди хэрэглээг нэвтрүүлэн Update Your Sensation уриатайгаар худалдаанд гаргасан.



НИЙСЛЭЛ
(0.5л лааз, 5%)

Их хотын залуусын хэмнэлийг мэдрүүлэгч Нийслэл шар айраг нь 2017 онд нийслэл Улаанбаатар хотын бахархал болсон Сүхбаатарын хөшөөний дүрсийг лаазны нэг тал дээр хэвлэн хязгаарлагдмал тоогоор худалдаанд гаргасан билээ.



БОРГИО
(0.45л шил, 0.5л лааз, 2-2.5л, ПЕТ, 5.5%)

Үлэмжийн чанар, Монголын бахархал "Боргио" шар айргийг 1927 онд анх үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2017 онд 90 жилийн ойг тохиолдуулан "Эх орны шар айраг 90 жил" гэсэн агуулгыг нэмэлтээр савлагаан дээр оруулсан билээ.



КАЛТЕНБЕРГ
(0.5л лааз, 5.5%)

Герман улсын Баварийн вангийн удмын зуун дамжсан туршлагыг шингээсэн улаан буудайн, шүүлтүүргүй шар айраг болох Калтенберг брэндийг 2017 онд лаазанд савлан худалдаанд гаргалаа. Тус шар айргийг Баварийн өвөг дээдсээс уламжлагдан ирсэн технологиор үйлдвэрлэдэг бөгөөд 5.5%-ийн спиртийн агууламжтай.



(0.45л шил, 0.33л шил, 5.1%)

Монголын Премиум шар айраг болох Алтан говь брэнд зөвхөн шинэ жилд зориулан өнгө нэмлээ. 5.1%-ийн спиртийн агууламжтай.



PRIME

(0.45л шил, 0.5 лааз шил, 4.6%)

2017 онд 90 жилийн ойг тохиолдуулан Боргио брэндийн премиум төрлийг зах зээлд танилцуулсан.



SERUUN SUPER LIGHT

(0.45 шил, 0.5л лааз, 2.5л ПЭТ)

Зөөлөн шар айргийг таашаан уух хүсэлтэй хэрэглэгчдэд зориулан гаргасан Монголын хамгийн бага алкоголийн агууламжтай Сэрүүн Super Light нь зах зээл 2017 оны 6 сард Сэрүүн брэндийн шинэ гишүүн болон худалдаанд гарсан.



МААМУУ АМТЛАГ СҮҮ

(125мл)

200 мл савлагаатай Маамуу сүүнүүд шинэчлэгдэж илүү эгдүүтэй боллоо. Маамуу брэнд нь хүүхдэд зориулан гаргасан Монголын анхны брэнд бөгөөд Маамуу уудаг йогурт, амтлаг сүү болон жүүс гэсэн 3 төрөлтэй. 2017 онд Маамуу амтлаг сүүний 200 мл савлагааг 125 мл болжгож багассан.

ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД



ЗАСАГЛАЛ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр: АПУ
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани
МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: I
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 4870 ⁴
Хувьцааны тоо ширхэг: 1,604,181,553 ⁵
Хувьцааны төрөл: энгийн
Халаасны хувьцааны тоо: 1,206,810
Компанийн эрх барих дээд удирдлага: Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)
ХЭХ-ын чөлөө цагт компанийн удирдлага: Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)
Өдөр тутмын удирдлага: Гүйцэтгэх захирал (хувь хүн)

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

2017 оны онцлох үйл явдал болох Нэгтгэх ажиллагааны үр дүнд Хайнекен Азия Пасифик Пте.Лтд нь АПУ ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл⁶:

1. Туул интернэшнл ХХК - 36.11%
2. Хайнекен Азия Пасифик Пте.Лтд – 25.00%
3. Вит Алъянс Лимитед - 14.03 %
4. Голомт банк ХХК - 13.77 %
5. Монголиан Бэвэриж Инвестментс ХХК - 5.19 %

2017 оны онцлох үйл явдал

1. Тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан; Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг тусгаарлаж, АПУ Дэйри ХХК гэх оноосон нэртэй охин компанийг үүсгэн байгуулж 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн;

2. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдаж, стратегийн хөрөнгө оруулагчдад зориулж хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргаж, үнэт цаасны төлбөрт ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг өрсөлдөгч компаниудын хувьцааг авсан;

Сингапур улсад бүртгэлтэй Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд (Спирт бал бурам ХХК, СББ Трейд ХХК, М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК-иудын толгой компани), АПУ Трейдинг ХХК, Улаанбаатар спирт ХХК, Депод ХХК, Натур агро ХХК-иудын хувьцааг 100% эзэмшигч Эвэргрийн Инвестментс ХХК нь АПУ ХК-д нэгдэж, ийнхүү нэгдсэний төлбөрт АПУ ХК-иас нэмж хувьцаа гаргаж Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигч болох Хайнекен Азия Пасифик Пте.Лтд, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нарт эзэмшүүлсэн. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсаныг 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн.

⁴ ҮЦТХТ ХХК-аас 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болж гаргасан Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа


⁵ Халаасны хувьцаа багтсан тоо

⁶ ҮЦТХТ ХХК-аас 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөр тасалбар болж гаргасан Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа

ОХИН КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

1. Сингапур Улсын хуулийн дагуу байгуулагдсан Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд (Mongolian Beverages Company Pte.Ltd)
 2. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан Спирт бал бурам ХХК
 3. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан СББ Трейд ХХК
 4. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан М Си Эс Азия Пасифик Брюэри ХХК
 5. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан АПУ Трейдинг ХХК
 6. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан Депод ХХК
 7. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан Улаанбаатар спирт ХХК
 8. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан Натур агро ХХК
 9. Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан АПУ Дэйри ХХК
 10. Оросын Холбооны Улсын хуулийн дагуу байгуулагдсан Гранд ХХК
 11. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хуулийн дагуу байгуулагдсан Чингис хаан Интернэшнл Лимитэд
-

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЗУРАГЛАЛ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ

2017 ОНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ

Бүтэц бүрэлдэхүүн: 9 гишүүнтэй, түүнээс 3 нь хараат бус.
Бүрэн эрхийн хугацаа: 3 жил (улиран сонгогдох боломжтой)
Зохион байгуулалтын хэлбэр: Хурал

2017 оны ТУЗ-ийн хурлын статистик:

- ээлжит хурал: 4 удаа
- ээлжит бус хурал: 6 удаа
- хурлын дундаж ирц: 89%
- гаргасан тогтоол шийдвэрийн тоо: 41

Чиг үүрэг:

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг төлөөлж компанийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хянах үүрэгтэй. Өөрийн чиг үүргийг гүйцэтгэхдээ, ТУЗ нь Компани, түүнтэй харилцан хамааралтай этгээд болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг удирдамжаа болгодог.
- АПУ Компанийн бизнесийн стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг нь хангуулах, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй ажиллах, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоо хуульд нийцсэн байх, Компанийн үйл ажиллагаа нь нийгмийн хариуцлагын зарчмыг даган мөрдөх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан байх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.
- АПУ Компанийн бизнесийн стратеги болон тулгарч буй эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцооны үйл ажиллагааг жилд хамгийн цөөндөө нэг удаа хянан хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гарган ажилладаг.

Мэргэжлийн хороод: Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал

ТУЗ-ийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журам:

- Компанийн дүрэм
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын дотоод журам
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны ажиллах журам
- ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам
- ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны ажиллах журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх журам
- Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам
- Ногдол ашгийн бодлого
- Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны журам

ТУЗ-ийн ажлын алба:

- ТУЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцдаг бөгөөд ТУЗ-ийн ажлын албын үйл ажиллагааг удирдан ажиллана.
- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалтай холбоотой асуудлыг шууд хариуцах эрх бүхий албан тушаалтан болно.

Бүрэлдэхүүн

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ дараах бүрэлдэхүүнтэй байв, үүнд:

1. П.Батсайхан (ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга),
2. Б.Батбаяр (ердийн гишүүн)
3. П.Батчимэг (ердийн гишүүн)
4. Г.Ганболд (ердийн гишүүн)
5. С.Громов (ердийн гишүүн)
6. Ж.Үнэнбат (хараат бус гишүүн)
7. Ё.Гэрэлчулуун (хараат бус гишүүн)
8. Ө.Батбаяр (хараат бус гишүүн)
9. С.Сайнбат (хараат бус гишүүн)
10. Ч.Ариунсан (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)

Гишүүдийн мэргэжил, ажлын туршлага



П.Батсайхан

Инженер мэргэжилтэй.
1993-1996: Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал;
1997-2008: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал;
2002 оноос хойш: АРУ Company-ийн ТУЗ-ийн дарга;
2004-2008: АРУ Company-ийн Гүйцэтгэх захирал;
2008 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч;
2010 оноос хойш: Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



С.Громов

Инженер мэргэжилтэй;
1992-1994 онд ОХУ-ын "Разноимпорт" ХХК-д менежер;
1994-2000 онд "Транс-ворлд Аллюминум" компанийн Лондон дахь;
салбарын захирал
2001 оноос одоог хүртэл Чингисхаан банкны ТУЗ-ийн дарга;
2013 оноос одоог хүртэл АРУ Company-н ТУЗ-ийн гишүүн.



П.Батчимэг

Багш мэргэжилтэй.
1988-1994: Орос хэлний багшийн дээд сургууль;
1995-2000: Цагдаагийн академид багш, ахлах багш;
2000-2003: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд мэргэжилтэн;
2004 оноос хойш: АПУ импекс ХХК, АПУ Трейдинг ХХК-ийн Ерөнхий захирал;
2005-2017: АРУ Company-н ТУЗ-ийн гишүүн;
2008 оноос хойш: Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч;



Б.Батбаяр

Эдийн засагч мэргэжилтэй.
1994-1996: МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш;
1999-2001: Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх;
2002-2012: Европын сэргээн босголт, хөгжлийн банкинд Ахлах мэргэжилтэн;
2012 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал;
2013 оноос хойш: АРУ company-н ТУЗ-ийн гишүүн;



Г.Ганболд

Эдийн засагч мэргэжилтэй.

1994-1996: МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш;

1999-2001: Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх;

2002-2012: Европын сэргээн босголт, хөгжлийн банкинд Ахлах мэргэжилтэн;

2012 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал;

2013 оноос хойш: APU Company-н ТУЗ-ийн гишүүн;



Ө.Батбаяр

Инженер, эдийн засагч мэргэжилтэй.

1998 оноос хойш: Баттур трейвэл ХХК-ийн Ерөнхий захирал;

2008 оноос хойш: Улаанбуудайн эх газар ХХК-ийн Ерөнхий захирал;

2014 оноос хойш: Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга;

2017 оноос хойш: Прокон майнинг Монгол-Канадын хамтарсан компанийн ТУЗ-ийн гишүүн;

2017 оны 6-р сараас хойш: APU Company-н ТУЗ-н хараат бус гишүүн;



Ж.Үнэнбат

Эдийн засагч мэргэжилтэй;

1990-2000 онд Монголбанкинд эдийн засагч, хэлтсийн дарга, Ерөнхийлөгч;

1996-2000 онд Азийн хөгжлийн банк, Монгол улсыг хариуцсан захирал;

2000-2006 онд Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал;

2009-2015 онд Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал;

2015 оноос одоог хүртэл Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал, Ерөнхий нарийн бичгийн дарга;

2013 оноос одоог хүртэл APU Company-н ТУЗ-ийн гишүүн;



Ё.Гэрэлчулуун

1981-1989: МУИС, БДС, УАМДИ-д-д багш;

1989-1991: Сайд нарын зөвлөлд референт;

1991-1993: Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга;

1993-1996: Үйлдвэрийн газрын Өөрчлөн байгуулалтын төвийн захирал;

1996-2000: УИХ-ын гишүүн;

2000-2006: ЗХАН-н ЕНБД, "Эх орон-Ардчилал" бүлгийн ажлын албаны дарга;

2006-2008: Шадар сайдын ахлах зөвлөх;

2008-2010: ХУД, ИТХ-ын ажлын албаны дарга;

2010-2012: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга;

2012-2016: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;

2017 оны 3-р сараас хойш: APU Company-н ТУЗ-ийн хараат бус гишүүн;



С.Сайнбат

Инженер, архитекторч мэргэжилтэй.
1992 онд Улаанбаатар хотын 6 дугаар дунд сургууль төгссөн;
1997-2001 он Германы техникийн их сургууль Архитекторч мэргэжлээр төгссөн;
2000-2008 онд АНУ-д ажиллаж, амьдарч байсан;
2008 оноос хойш "Цэгц Буянт" ХХК-ийн Ерөнхий Захирал;
2017.08-12 сар: АПУ company -н ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ч.Ариунсан

Бизнесийн удирдлагын магистр
2004-2005: Винсвэй групп, бизнес менежер
2005-2007: ЖК ХХК, төслийн менежер
2007-2008: ДэРой санхүүгийн зөвлөх компани, хөрөнгө оруулалтын менежер
2008-2017: АПУ ХК, Олон улсын харилцаа экспортын албаны дарга
2012 оноос хойш АПУ company -н ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ХОРООД

**ТУЗ нь дэргэдээ Аудитын хороо
Цалин урамшууллын хороо
Нэр дэвшүүлэх хороотой
Хороодын бүрэлдэхүүнийг дэлгэрэнгүй дурьдвал:**

Аудитын хороо:

Ж.Үнэнбат (хорооны дарга), Б.Батбаяр, Ө.Батбаяр

Хорооны чиг үүрэг: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх явдлыг хангуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнал, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

2017 онд 3 удаа хуралдаж санал дүгнэлт гаргасан байна.

Цалин урамшууллын хороо:

Б.Батбаяр (хорооны дарга), Ж.Үнэнбат, Ё.Гэрэлчулуун

Хорооны чиг үүрэг: Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж хянах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үндсэн чиг үүрэгтэй.

2017 онд 2 удаа хуралдаж санал дүгнэлт гаргасан байна.

Нэр дэвшүүлэх хороо:

П.Батсайхан (хорооны дарга), Ё.Гэрэлчулуун, Ө.Батбаяр

Хорооны чиг үүрэг: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох ажлыг зохион байгуулах, нэр дэвшүүлэх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үндсэн чиг үүрэгтэй.

2017 онд 3 удаа хуралдаж санал дүгнэлт, шийдвэр гаргасан байна.

2018 ОНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ



П.Батсайхан

ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Инженер мэргэжилтэй.

1993-1996: Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал;
1997-2008: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал;
2002 оноос хойш: АПУ company -н ТУЗ-ийн дарга;
2004-2008: АПУ company -н Гүйцэтгэх захирал;
2008 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч;
2010 оноос хойш: Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



Kenneth Choo

ТУЗ-ийн ердийн гишүүн

Нягтлан бодогч, менежмент боловсролтой (CA),

1992-1994: Ахлах аудитор, PWC

1997-2003: Бүс нутаг хариуцсан захирал/ Дэд ерөнхийлөгч VP, Royal Ahold/CRC Ahold company

2003-2012: Бизнес хөгжил хариуцсан захирал, Heineken

2013-2015: Захирал/ Дэд захирал/ Бүс нутаг хариуцсан захирал, Heineken (APB, Singapore, Indochina)

2015 – одоог хүртэл: Захирал, Heineken Asia Pacific

2017.01.25-р сараас хойш: АПУ company -н ТУЗ-ийн гишүүн



Б.Батбаяр

ТУЗ-ийн ердийн гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй.

1994-1996: МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш;

1999-2001: Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны банкны зөвлөх;

2002-2012: Европын сэргээн босголт, хөгжлийн банкинд Ахлах мэргэжилтэн;

2012 оноос хойш: Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал;

2013 оноос хойш: АПУ company -н ТУЗ-ийн гишүүн.



Jasper Hamaker

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүүгийн менежмент, эконометрикс мэргэжилтэй (CFA)

1990-1995: Jonge демократен, Netherlands

2003-2005: Санхүүгийн хяналт хариуцсан менежер, Nigerian Breweries/Heineken

2006-2010: Санхүүгийн захирал, PT Multi Bintang Indonesia Tbk

2010-2014: Санхүүгийн захирал, Nigerian Breweries/Heineken

2014–одоог хүртэл Бүс нутгийн санхүү хариуцсан тэргүүн захирал/Heineken

2017.01.25-р сараас хойш: АПУ company -н ТУЗ-ийн гишүүн



Г.Ганболд

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүүгийн менежмент, эконометрикс мэргэжилтэй (CFA)

Инженер, эдийн засагч мэргэжилтэй.

1983-1990: МХЗЭ-ийн Төв хорооны Хэлтсийн эрхлэгч, Нарийн бичгийн дарга;

1991-1993: Монголын залуучуудын холбооны Тэргүүлэгч;

1998-2000: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Тэргүүн дэд дарга;

2000-2015: Голомт банкны Дэд ерөнхийлөгч, Газрын захирал, Тэргүүн дэд захирал;

2015-2016: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Дэд дарга;

2016 оноос хойш: Голомт банкны Ерөнхийлөгч;

2017 оны 3-р сараас хойш: АПУ company -н ТУЗ-ийн гишүүн



С.Громов

ТУЗ-ийн ердийн гишүүн

Инженер мэргэжилтэй.

1992-1994: ОХУ-ын "Разноимпорт" ХХК-д Менежер;

1994-2000: "Транс-ворлд Аллюминум" компанийн Лондон дахь салбарын захирал;

2001-2016: Чингисхаан банкны ТУЗ-ийн дарга;

2006 оноос хойш: Монгол Даатгал компанийн ТУЗ-ийн дарга

2013 оноос хойш: АПУ company -н ТУЗ-ийн гишүүн.



Ө.Батбаяр

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Инженер, эдийн засагч мэргэжилтэй.

1998 оноос хойш: Баттур трейвэл ХХК-ийн Ерөнхий захирал;

2008 оноос хойш: Улаанбуудайн эх газар ХХК-ийн Ерөнхий захирал;

2014 оноос хойш: Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга;

2017 оноос хойш: Прокон майнинг Монгол-Канадын хамтарсан компанийн ТУЗ-ийн гишүүн;

2017 оны 6-р сараас хойш: АПУ company -н ТУЗ-н хараат бус гишүүн



Ё.Гэрэлчулуун

ТУЗ-ийн хараат бус гишүүн

1981-1989: МУИС, БДС, УАМДИ-д-д багш

1989-1991: Сайд нарын зөвлөлд референт

1991-1993: Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын нарийн бичгийн дарга

1993-1996: Үйлдвэрийн газрын Өөрчлөн байгуулалтын төвийн захирал

1996-2000: УИХ-ын гишүүн

2000-2006: ЗХАН-н ЕНБД, "Эх орон-Ардчилал" бүлгийн ажлын албаны дарга

2006-2008: Шадар сайдын ахлах зөвлөх

2008-2010: ХУД, ИТХ-ын ажлын албаны дарга

2010-2012: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга

2012-2016: Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга

2017 оны 3-р сараас хойш: АПУ company -н ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ж.Үнэнбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Эдийн засагч мэргэжилтэй.

1990-2000: Монгол банкинд эдийн засагч, хэлтсийн дарга, Ерөнхийлөгч

1996-2000: Азийн хөгжлийн банк, Монгол улсыг хариуцсан захирал

2000-2006: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал

2009-2015: Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал

2015 оноос хойш: Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал,

Ерөнхий нарийн бичгийн дарга

2013 оноос хойш: АПУ company -н ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ч.Ариунсан

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Бизнесийн удирдлагын магистр

2004-2005: Винсвэй групп, бизнес менежер

2005-2007: ЖК ХХК, төслийн менежер

2007-2008: ДэРой санхүүгийн зөвлөх компани, хөрөнгө оруулалтын менежер

2008-2017: АПУ ХК, Олон улсын харилцаа экспортын албаны дарга

2012 оноос хойш АПУ company -н ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ШИЙДВЭР ГАРГАХ ПРОЦЕСС

APU Company-н ТУЗ-ийн ээлжит хурал улирал бүр хуралдах ба шаардлагатай бол ээлжит бус хурал болон эчнээ санал хураалтаар шийдвэр гаргана. Шийдвэрийг хуралд оролцсон гишүүд, эчнээ хураасан саналын дийлэнх олонхиор гаргана. Мөн түүнчлэн, Монгол Улсын Компанийн тухай хуульд зааснаар, их хэмжээний хэлцлийн тухайд зөвхөн санал нэгтгэйгээр шийдвэр гаргах (санал зөрсөн тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх), ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухайд ийм сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн саналаа түдгэлзүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажиллана.

Их хэмжээний хэлцэл

2017 оны санхүүгийн жилд хийгдсэн болон үргэлжилсэн их хэмжээний хэлцэл, түүний үнийн дүн:

- АПУ ХК ба Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хооронд байгуулагдсан Нэгтгэх гэрээ
Үнийн дүн: 338,127,000,000 төгрөг
- АПУ ХК ба АПУ Трейдинг ХХК-ийн хооронд байгуулагдсан бүтээгдэхүүн борлуулалтын Хамтран ажиллах гэрээ
Үнийн дүн: 223,246,739,903 төгрөг

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2017 оны ажил гүйлгээ хийгдсэн хамааралтай талуудын жагсаалтыг доор харууллаа.

1. АПУ Трейдинг ХХК
2. АПУ Дэйри ХХК
3. Депод ХХК
4. Туул Интернэйшнл ХХК
5. Зеннор Интернэйшнл ХХК
6. Гранд ХХК
7. Вит Альянс Лимитэд
8. Скайтел ХХК
9. Медиа групп ХХК
10. Капитал групп ХХК
11. Шунхлай ХХК
12. Шунхлай трейдинг ХХК
13. Хьюндай моторс Монгол ХХК
14. Киа моторс Монгол ХХК
15. Паблик Медиа ХХК
16. УБ Спирт ХХК
17. Пауэр Юнит ХХК
18. Сантранс Монгол ХХК
19. Эм Би Си ХХК
20. Интернейшнл Медикал Центр ХХК
21. Натур Агро ХХК
22. Грейт Импайр ХХК
23. Шунхлай Групп ХХК
24. NTV Broadcasting LLC
25. GSB Mining LLC
26. Ван трейд ХХК
27. Скай медиа корпораци ХХК
28. Спирт бал бурам ХХК
29. СББ Трейд ХХК
30. М си Эс Азия пасифик брьюэри ХХК
31. Монголиан Бевериж Инвестментс ХХК
32. Голомт Банк
33. Жи Эс Би Капитал ББСБ
34. Эс Ди Сервис ХХК
35. Эс Девелопмент ХХК
36. Эс Ди Инженеринг энд Консалтинг ХХК
37. Блю Скай Кашемир ХХК
38. Гофро ХХК

2017 оны санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлүүд:

Санхүү байдлын тайланд тусгагдсан дүн: 400,294,328,079 төгрөг. Үүнээс: Эвэргрийн Инвестментс ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт- 338,127,000,000 төгрөг, АПУ Дэйри ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт 54,619,000,000 төгрөг

Дэлгэрэнгүй орлого үр дүнгийн тайланд тусгагдсан дүн: 257,888,509,854 төгрөг. Үүнээс: АПУ Трэйдинг ХХК-тэй хамтран ажиллах гэрээний дагуу борлуулсан бүтээгдэхүүний дүн: 223,246,739,903 төгрөг

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Компанийн ерөнхий бодлого

АПУ Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоондоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг татан ажиллуулж, тогтвор суурьшилтай ажиллахад нь анхаарах;
- Ажилтан, ажиллагсдын зохистой карьерийн удирдлагыг хангах зорилгоор албан тушаал дэвшүүлэх, тасралтгүй суралцах нөхцөл боломж бүрдүүлэх, гадаад дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох;
- Ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэн, гүйцэтгэлд тохирсон урамшуулал олгох;
- Ажилтнуудын нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор нийгмийн хөгжлийн сан бүрдүүлж, тэтгэмж, дэмжлэг олгох;
- Жил бүр цалин хөлсний судалгаа хийж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, макро эдийн засгийн төлөв, инфляцийн түвшинтэй уялдуулан цалин хөлсний түвшингээ нэмэгдүүлэх.

ТУЗ-ийн цалин урамшуулал

ТУЗ-ийн гишүүдэд сар бүр 2,000,000 төгрөгийн цалин хөлс олгодог бөгөөд үйл ажиллагааны гүйцэтгэлтэй уялдсан урамшууллын тогтолцоо байхгүй.


ХУВЬЦАА

Хувьцааны мэдээлэл

1992 онд Архи пиво комбинатаас Архи, пиво, ундаа буюу АПУ Хувьцаат компани болон 49%-ийг хувьчилж, 2001 онд үлдсэн 51 хувийг дуудлага худалдаанд оруулан өмчлөх эрхийг шилжүүлсэнээр 100% хувьчлагдсан. АПУ Компани нь 2005 онд Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авсан бөгөөд хууль эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирснаар нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр Улсын бүртгэлд бүртгэгдсэн. АПУ ХК нь зах зээлд арилжаалагдаж буй хувьцааны тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2008 болон 2016 онуудад хувьцааг 100 болон 10 дахин тус тус хуваасан бөгөөд эерэг үр дүн авчирсан юм.

Стратегийн хөрөнгө оруулагчтай хамтрах зорилгоор АПУ ХК нь нэгдлийн үйл ажиллагааг 2017 оны эхнээс эхлүүлсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/199 тоот тушаалаар АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Ингэснээр АПУ ХК - нь зах зээл дэх хувьцааны тоо 1,064,181,553 ширхэг болсон юм.

2017 оны 12-р сарын 5-ны өдөр АПУ ХК-ийн хувьцааны ханш 906.8 төгрөгт хүрснээр зах зээлийн үнэлгээ 950 тэрбум төгрөгт хүрч, түүхэнд дээд амжилт тогтоосон. 2017 оны эцсийн байдлаарх АПУ ХК - ын үнэлгээ 762 тэрбум төгрөг байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Ногдол ашгийн бодлого

APU company нь 2005 онд хувьчлагдсанаас хойш ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлж хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой түвшинд байлгах бодлого баримтлан ажиллаж байна.

Ногдол ашгийг хууарилах шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг юм.

АПУ ХК-н хувьд хувьцаа эзэмшигчиддээ 2005 оноос одоог хүртэл ногдол ашгийг тасралтгүй тарааж ирсэн бөгөөд "Нэгж хувьцаанд тогтмол ногдуулах" ногдол ашгийн бодлого барьж ирсэн.

2017 онд манай компани нийт 10,6 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа 10 төгрөгийн ногдол ашиг тараахаар ТУЗ-н тогтоол гаргасан билээ.

Өнгөрсөн хугацаанд АПУ ХК-н олгож байсан ногдол ашгийн дундаж хэмжээг тооцвол Олон Улсын шингэн хүнсний томоохон компаниудын дундаж үзүүлэлт болох 1.07%-тай ойролцоо түвшинд байна.

	Ногдол ашиг тараасан хувьцаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Нийт ногдол ашиг /сая.төг	Dividend yield per share
2006 он	742,877	60	45	
2007 он	742,877	538	400	2.80%
2008 он	74,287,700	10	743	2.30%
2009 он	74,167,019	20	1,483	3.20%
2010 он	74,167,019	40	2,967	2.00%
2011 он	74,167,019	60	4,450	1.40%
2012 он	74,167,019	70	5,192	1.80%
2013 он	74,167,019	90	6,675	2.20%
2014 он	74,167,019	0	-	
2015 он	74,167,019	70	5,192	1.80%
2016 он	741,670,190	1	742	0.25%
2017 он	1,064,181,553	10	10,642	1.40%

Дундаж /ногдол ашгийн хувь/

1.91%

	Div. Yield %
Beverage industry average	1.07
Anheuser-Busch Inbev SA	3.42
Heineken N.V. (HEIA.AS)	1.71
Carlsberg B	2.25

Эх сурвалж: finance.yahoo.com and NYU Stern

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

2017 онд Гүйцэтгэх захирлын дэргэд, түүнийг шийдвэр гаргахад зөвлөх, туслах чиг үүрэг бүхий гишүүдтэй Захирлын зөвлөлтэйгөөр ажилласан бол бизнесийн зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оноос АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Санхүү эрхэлсэн захирал, Стратеги эрхэлсэн захирал, Маркетинг эрхэлсэн захирал, Борлуулалт эрхэлсэн захирал, Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал, Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал, Экспортын үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Спирт Бал Бурам ХХК-н үйл ажиллагаа эрхэлсэн захирал болон АПУ Дэйри ХХК-н гүйцэтгэх захирал гэсэн удирдлагын багаар ажиллаж эхлээд байна.

2017 онд томилогдон ажилласан Гүйцэтгэх удирдлагын баг



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
хариуцсан захирал



БАНЗРАГЧИЙН ТҮВШИН
Санхүү хариуцсан захирал



АВИРМЭДИЙН МЭНДБАЯР
Төсөл хариуцсан захирал



АРИУНАА ДАНДАРОВА
Харилцаа, инноваци хариуцсан
захирал



БАДРУУГАН НАРАНЗУН
Захиргаа, Хүний нөөц хариуцсан
захирал

2018 онд шинээр томилогдсон Гүйцэтгэх удирдлагын баг



ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэх захирал



ХОУ ТЭЙК ПЭН
Үйлдвэрлэл, Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



БАНЗРАГЧИЙН ТҮВШИН
Санхүү эрхэлсэн захирал



ЯДАМДОРЖИЙН ДАМДИНСҮРЭН
Стратеги эрхэлсэн захирал



АРИУНАА ДАНДАРОВА
Маркетинг эрхэлсэн захирал



ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ
Борлуулалт эрхэлсэн захирал



ШИПИЛОВЫН ДӨЛГӨӨН
Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал



БАДРУУГАНЫН НАРАНЗУН
Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал



ГАНБААТАРЫН ГАНЗОРИГ
Экспорт эрхэлсэн захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
АПУ Дэйри ХХК-н Гүйцэтгэх захирал



САНЖИЙН ГАНЗОРИГ
Спирт Бал Бурам ХХК-н
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Өнгөрсөн жилүүдэд АРУ компани компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналт, Дотоод аудитын цогц бодлогуудыг боловсруулж батлуулсанаар эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг эрчимжүүлж ажилласан.

Харин 2017 оны сүүлээр хийгдсэн бизнесийн нэгдэл, нийлэлтийн үр дүнд компани дотоодын зах зээлд, шингэн хүнсний салбарт тэргүүлэх байр сууриа улам бэхжүүлж байгаа хэдий ч цаашид одоогийн зах зээлээ бүс нутаг болон олон улсад тэлэхээр зорьж байгаа тул компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ажиллах шаардлага тулгарч байгаа юм. Энэ утгаараа шингэн хүнсний салбарт Дэлхийд тэргүүлэгч, HEINEKEN компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахаар зорьж байна.

ЭРСДЭЛИЙН ПРОФИЛЬ

Компанийн өөрийн үйл ажиллагаанаас үл хамааран хувьсан өөрчлөгдөж байгаа гадаад орчин, нөхцлөөс шалтгаалж олон төрлийн эрсдлүүд шинээр үүссээр байна. Гадаад орчны нөлөөлөл тэр дундаа манай орны хувьд улс төр, засгийн газрын бодлого, эдийн засгийн тодорхойгүй байдлын улмаас зөвхөн манай компанид төдийгүй салбарын бусад компаниудад ч тодорхойгүй байдал үүсч, олон төрлийн нөлөөлөл үзүүлж улмаар гадаад эх үүсвэрээс үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдлуудыг нэмэгдүүлж байгаа юм.



2018 ОНЫ ӨНДӨР ЭРСДЭЛҮҮД

БИЗНЕСИЙН НЭГДЭЛИЙН ЭРСДЭЛ

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ

Бизнесийн нэгдэл, нийлэлтийн үр дүнд компани дотоодын зах зээл /архи, шар айрагны зах зээл/ дээр тэргүүлэх байр сууриа улам бататгах цаашлаад олон улсад зах зээлээ тэлэх боломжийг бий болгож байгаа хэдий ч нэгтгэж буй компаниудын соёл, стратеги бодлого, шийдвэр гаргалт, бизнесийн загвар ба процесс, үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй нэгтгэж чадахгүй байх, гол ажилчдаа алдах, ажилчдын гүйцэтгэл муудах, харилцаа үр ашиггүй, ил тод бус болох улмаар нэгдэл, нийлэлт амжилтгүй болох зэрэг томоохон эрсдэлийг дагуулж болзошгүй.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ

Тохиолдож болох энэхүү эрсдэлийг удирдахын тулд бид систем, хүмүүс, процесс гэсэн үндсэн 3 чиглэлд анхаарч ажиллана. Юуны түрүүнд нэгдэж буй компаниудын бүхий л зүйлсийг тодорхой болгох, тухайлбал мэдээллийн урсгалыг хурдтай, тодорхой болгох /ямар өөрчлөлтүүд бий болох, цаашид өөрчлөлт хэрхэн явагдах г.м/ мөн ажилчдыг аль болох эрт процесс, үйл ажиллагаанд оролцуулах, тогтмол сургалтанд хамруулж өөрчлөлт, шинэчлэлтэд богино хугацаанд дасан зохицож, үр бүтээлтэй ажиллахад дэмжлэг үзүүлэхэд голлон анхаарч ажиллах болно.

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ

/Татварын өсөлт/

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ

Улс төрийн тогтворгүй байдал, засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогуудын өөрчлөлтөөс хамаарч бизнесийн орчинд тодорхойгүй байдал үүсч, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хууль эрхзүйн өөрчлөлтүүд гарсан. Тухайлбал ХХОАТ, НДШ, ААНОАТ, ОАТ-ын хувь хэмжээг шат дараалан нэмэгдүүлж байгаа нь компанийн хувьд татварын зардал өсөх, улмаар ашиг буурах зэрэг сөрөг үр дагаваруудыг үүсгэж байна.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ

Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэл тул компанийн зүгээс энэхүү эрсдэлийг удирдах, ямар нэг хариу арга хэмжээ авах нь ихээхэн хүндрэлтэй байдаг. Гэхдээ цаашид нэг эх үүсвэрээс шалтгаалсан олон төрлийн салбарласан эрсдэл нэмж үүсэхээс зайлсхийх зорилгоор компани үйл ажиллагааныхаа зардлыг бууруулах, хууль, дүрэм, журмын нийцлийг хангах, салбарын хувьд үнийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зэргээр аливаа үр дагаврыг бууруулж ажиллахыг зорьж байна.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨСӨЛТ

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ

2016 онтой харьцуулахад 2017 онд голлох валютын ханш тус бүр дунджаар 10 хувиар өссөн ба тэр дундаа ам доллар, юанийн ханш харгалзан 14%, 30%-р төгрөгийн эсрэг чангарсан юм. Энэ нь нийт татан авалтын дийлэнх хувийг ам доллараар төлдөг манай компанийн хувьд ТЭМ-ын зардал өсөх үр дагаварыг нэмэгдүүлж байна.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ

Энэ төрлийн гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэлийг удирдахад хүндрэлтэй ч ханшийн өсөлт, түүнээс үүсэх үр дагаврыг бууруулах зорилгоор бид валютын ханшийн хэлбэлзэл, трендийг тогтмол судалж шийдвэр гаргалтанд ашиглахыг зорьдог ба бууралттай үед нөөцөө төвлөрүүлэх, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг эрмэлзэж ажилладаг.

ЭДИЙН ЗАСГИЙН УДААШРАЛ

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ

Өнгөрсөн онтой харьцуулахад ДНБ-н өсөлт нэмэгдэж, эдийн засаг сэргэж эхэлсэн хэдий ч бизнест бодит эерэг нөлөөлөл үзүүлээгүй байна. Эдийн засгийн энэхүү удаашрал, тогтворгүй байдал нь компанийн эцсийн хэрэглэгчийн худалдан авах чадварт нөлөөлөхөөр барахгүй, томоохон харилцагчдаа алдах эрсдэлийг дагуулж байна.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ

Манай компани нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процесст чанар стандартыг өндөр түвшинд ханган ажилладаг ба хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн, дээд зэргийн чанартай, тунгалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх түүгээрээ дамжуулан зохистой хэрэглээг нийгэмд таниулах, нийгмийн хариуцлагыг дээдлэн ажиллах замаар уг эрсдэлийг удирдан ажиллахыг зорьдог.

ӨРСӨЛДӨӨН

ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ

Бизнесийн нэгдэл, нийлэлтийн үр дүнд компани дотоодын зах зээлд болон шингэн хүнсний салбарт тэргүүлэх байр сууриа улам бэхжүүлэхээр харагдаж байгаа ч цаашид одоогийн зах зээлээ бүс нутаг болон олон улсад тэлэхээр зорьж байгаа нь өрсөлдөөнийг улам нэмэгдүүлэх магадлал өндөр юм.

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ

Бид одоогийн зах зээлээ бүс нутаг болон Олон Улсад тэлэхийн тулд дараах чиглэлд онцгой анхаарч ажиллана. Үүнд:

- Хэрэглэгчид бүтээгдэхүүнтэй холбоотой юуг илүүд үзэж буйг, юуг сонирхож, юунд хөрөнгө оруулалт хийж буйг тодорхойлох, тэдний хүлээлтэд нийцсэн эргэх холбоог сайжруулах
- Хэн бидний өрсөлдөгч болохыг таних, тодорхойлох, тэдний үйл хөдлөлийг судлах,
- Судалгаа хөгжүүлэлт болон инновацийг хөгжүүлэх, энэ чиглэлт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Мэргэжлийн баг бүрдүүлэх, экспертүүдээс тусалцаа авах зэргээр аливаа учирч болох өрсөлдөөний эрсдэлийг таньж, тодорхойлох, удирдан ажиллах,
- Зах зээлийн хөдөлгөөнд мониторинг хийснээр аливаа эрсдэлийг бизнесийн боломж болгон хувиргахад ихээхэн анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

ШАГНАЛ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АЗИЙН ЗАГВАР БАЙГУУЛЛАГА

Азийн бүтээмжийн байгууллага

ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим

НИЙСЛЭЛИЙН ОНЫ ШИЛДЭГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ БАЙГУУЛЛАГА

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ КОМПАНИ

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам

RED DOT AWARD 2017

Winner of Communication Design (VELVET)

ЭНТРЕПРЕНЕР 2017

Оны онцлох аж ахуй нэгж


BLOOMBERG AWARDS 2017

ШИЛДЭГ МЕНЕЖМЕНТ

ОНЦЛОХ ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН – МААМУУ БРЭНД

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим





ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТОГВОРТОЙ БАЙДЛЫН БОДЛОГО

APU Company-н баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үргэлж нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэнэ бүтээхэд чиглэж, "Тогтвортой Хөгжил"-ийн үндсэн суурь зарчим болох ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ тэнцвэртэй хөгжлийг хангахаас гадна ХҮНИЙ хөгжлийн тогтвортой бодлогод онцгойлон анхаарч, урт хугацаанд үр ашигтай ажиллахыг эрхэм зорилго болгосоор ирсэн билээ. Бид 2017 онд тогтвортой нийгэмд илүү их хувь нэмэр оруулах зорилгоор компанийн тогтвортой байдлын бодлогоо үндсэн 3 чиглэлд авч хэрэгжүүлэн ажиллалаа.

Тогтвортой хөгжил

ЭДИЙН ЗАСАГ

- Үр ашгийн хүртээмжтэй байдал
- Бүтээмжийг дээшлүүлэх замаар баялаг бүтээх
- Зардлыг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх
- БАЙГАЛЬ ОРЧИН
- Байгальд ээлтэй үйлдвэрлэл
- Хууль тогтоомж, стандартын нийцэл
- Үйл ажиллагааны байнгын сайжруулалт

Компанийн нийгмийн хариуцлага

НИЙГЭМ

- Хүнсний аюулгүй байдал, дээд зэргийн чанар, стандартыг хүргэх
- Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх
- Шударга, ил тод өрсөлдөөн
- Зохистой хэрэглээг дэмжин ажиллах
- Хэрэглээний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах
- Хууль эрх зүйн нийцэл
- Үл ялгаварлал, шударга байдал

Хувь хүний хөгжил

АЖИЛЧИДДАА

- Аюулгүй байдлыг эрхэмлэх
- Эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх
- Шинэ санал санаачлагыг дэмжих
- Өв соёл, зан заншлыг таниулах
- ОЛОН НИЙТЭД
- Хүүхэд, залууст чиглэсэн олон төрлийн үйл ажиллагаа
- Үндэсний өв соёл, зан заншлаа түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулах

ЭДИЙН ЗАСАГТ ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- АPU company-н 2017 оны татвар төлөлт нь Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6%, татварын орлогын 2.1%, онцгой албан татварын орлогын 18.3%, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 1.3%-ийг дангаар бүрдүүлэн ажилласан байна.
- 2017 онд Монгол улсын эдийн засаг, төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байсан бөгөөд АПУ ХК нийт 10.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг буюу нэгж хувьцаанд 10 төгрөгийн ногдол ашиг зарлахаар шийдвэрлээд байна.
- Бизнесийг илүү үр ашигтайгаар удирдах, Монгол улсын мал аж ахуй болон үйлдвэрлэлийн салбарт хувь нэмэх оруулах үүднээс сүүний бизнес нэгжийн тусгаарлан АПУ Дэйри ХХК-г байгуулаад байгаа юм. АПУ Дэйри ХХК-г байгуулснаар сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нийлүүлэлт, мал аж ахуй, фермерийн эдийн засгийн чадамжийг сайжруулахад чиглэсэн ажлуудыг хийх боломжтой болох юм.
- Мөн түүнчлэн татвар төлөлтийг нэмэгдүүлэх, Монгол улсын экспортын орлогыг өсгөх, импортыг орлуулах, бизнесийн сайн туршлагыг нутагшуулах ач холбогдол бүхий нэгдлийг үйл ажиллагаа 2017 онд болж өнгөрлөө.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийг ямагт анхааран нэн тэргүүнд байгаль орчинд ээлтэй техник, технологи, стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар байгальд ээлтэйгээр үйлдвэрлэл явуулахыг эрхэмлэдэг. Компанийн байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг боломжит бага түвшинд хүргэх явдал нь ажилчин нэг бүрийн хариуцлага юм. 2017 онд бид байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах үндсэн чиглэлийн хүрээнд дараах хэмнэлтүүдийг хийж ажилласан байна.

Эрчим хүчний хэмнэлт

Эрчим хүчний хэмнэлтийн төслийг 2015-2017 оны хооронд хэрэгжүүлж уур, ус, дулаан, цахилгааны эрчим хүчийг хэмнэх, эрчим хүчийг сэргээн дахин ашиглах зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр АПУ Company ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АЗИЙН ЗАГВАР БАЙГУУЛЛАГА болоод байгаа билээ. 2017 оны хувьд 200 мянган кВт цахилгаан, 467 гКал уурыг хэмнээд байна.

Усны хэмнэлт

Нийт үйлдвэрүүдийн хэмжээнд ус хэмнэх 12 төсөл хэрэгжүүлснээр жилд 14 000 тонн усыг дахин ашиглаж байна. Саарал ус төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн ногоон байгууламж, услах цистернуудийг цэнэглэн 3600м² ногоон байгууламж, 86 улиас мод, 136 бут сөөгийг услах; түгээлтийн машинуудын угаалга цэвэрлэгээн ашиглах, АПУ компанийн нийт ажилчдын хувцас угаалганд хэрэглэх зэргээр усыг үр дүнтэйгээр дахин ашиглаж байна.

ХҮНИЙ НӨӨЦ, ХӨГЖИЛ

Мөрөөдлөө биелүүлэхэд хормоор хэмжигдэж буй их хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах, сайхан ирээдүйг хамтдаа босгох, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах алтан боломжийг хүн бүрийн өмнө нээлттэй байлгахын төлөө АПУ company ажилладаг.

Монгол төдийгүй олон улсын түвшинд үнэлэгдсэн хүнсний манлай үйлдвэрлэгч, найдвартай ажил олгогч, дэлхийн шилдэг технологи, шийдлийг нэвтрүүлэгч АПУ company-д ажилласнаар өсөн дэвших, өөрийгөө хөгжүүлэх олон боломжийг өмнөө нээж өрсөлдөхүйц, цалин урамшуулал аюулгүй тохилог орчинд чадварлаг эвсэг бүтээлч хамт олны нэгэн хэсэг болон ажиллах боломжтой. Ажил хөдөлмөрөөрөө гаргасан амжилт, бүтээсэн үйлсдээ сэтгэл хангалуун байж, ирээдүйн төлөө хөгжлийн зүг хамтдаа алхахад АПУ company-н ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО оршино.

2017 оны хүний нөөцийн бодлогын хэрэгжүүлэлтийн хүрээнд:

АПУ компани нь 2017 онд ажилтануудынхаа хувь хүний хөгжилд чиглэсэн “Соёлоор гоёно” концепцийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажилласан ба хүний нөөцийн хөгжлийн хүрээнд хувь хүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 377 мэргэжлийн болон ажлын байрны сургалтуудыг амжилттай зохион байгуулсан.

Үүнд:

- Инженер, менежерүүддээ - “Хамтдаа хөгжицгөөе” англи хэлний сургалт, “Санхүүгийн боловсрол” сургалтыг дунд түвшний менежерүүдэд амжилттай зохион байгуулсан.
- Ажилтан бүрийн хувь хүний хөгжил манлайллыг хөгжүүлэх замаар сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, компаний үнэ цэнэ өсгөх зорилготойгоор “ТӨГӨЛДӨР ТӨСӨЛ” -ийн хүрээнд “Байгууллагын соёл ба та” сургалтыг нийт ажилтнуудад, “Сэтгэхүйн цар хүрээ” хандлага харилцааны сургалтыг нийт үйлдвэрийн ажилтнуудад тус тус амжилттай зохион байгуулсан.

Дээрх ажлын үр дүнг ажилчдаас авсан соёлын судалгаанаас харахад 2017 онд ажилтнуудын оролцоо: 3%, ажлын төлөвлөлт: 3.2%, харилцаа холбоо, ажлын уялдаа: 2.5% болж өнгөрсөн оныхоос тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Мөн бид Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан гэрээгээ 100% биелүүлж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,011,745,550 төгрөгийг зарцууллаа.

- Тэтгэвэр, тэтгэмж 78,395,963 төгрөг
- Дэмжлэг туслалцаа 182,123,825 төгрөг
- Шагнал урамшуулал 79,758,268 төгрөг
- Хүндэтгэл үзүүлэх-56,319,624 төгрөг
- Өдрийн хоол, эрүүл мэндийн үйлчилгээ, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд 1,011,745,550 төгрөгийн тусламж тус тус үзүүлсэн.

Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд хийгдсэн ажлууд:

- Ажилтнуудын ая тухтай ажил амралтыг зохицуулан хоолны газрыг тохижуулан илчлэг сайтай хоолоор тогтмол үйлчилж байна.
- Онцгой нөхцөлд ажилладаг ажилтнуудад өдөр бүр сүү, тараг, өвлийн улиралд аарц олгодог.
- Зөвхөн ажилчидаа үйлчилдэг АПУ эмнэлэгтэй бөгөөд эмнэлэг нь яаралтай болон анхан шатны тусламжийг үзүүлэх, ажлын байрнанд нь эмчлэн эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амьдралын зөв дадал, хэв маяг олгохтой холбоотой нийгэм эрүүл мэндийн зөвлөгөө тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Компаний эмнэлгээр өдөрт 20-25 ажилтан тогтмол үйлчлүүлдэг.

Бид 2018 оноос эхлэн 12 Life Saving Rules-ийг компанийн хэмжээнд танилцуулж нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БИД

“Тунгалаг туул аян-2017”

Нийгмийн хариуцлагаа ухамсарлагч АПУ компани нь тогтвортой хөгжлийн нэг чухал баримтлал болох байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах, хог хаягдлыг бууруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулах чиглэлийн хүрээнд ажилчдынхаа санаачилгыг дэмжиж “Тунгалаг Туул” аяныг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэ хугацаанд нийт мянга гаруй ажилчид болон бусад аж ахуй нэгжүүдийн төлөөллүүд оролцож 50 гаруй тонн хогийг цэвэрлэж, Туул голын эрэг дагуух газарт хог хаягдал хаях зориулалттай хогийн сав байрлуулж ажилласан байна.

“Тунгалаг Туул” аянд АПУ компанийн 300 ажилчид хамрагдсан төдийгүй бидний үйл ажиллагааг дэмжин Депод ХХК, Грийт Эмпайр ХХК, Цэц Зам Пласт ХХК, Сантранс Ложистикс ХХК зэрэг аж ахуй нэгжүүд мөн “Туул голын сав газрын захиргаа” болон ӨМӨЗО-ны харилцагч байгууллагын төлөөлөл болсон Өвөр Монгол залуус нэгдэж Туул голоо цэвэрлэх, хамгаалах үйлсэд хамтран ажилласныг дуулгахад таатай байна.

Save Infant

JCI Монгол байгууллагаас санаачилсан “SAVE LIFE” төсөлд хамтран Эх хүүхдийн эрдэм шинжилгээний үндэсний төвд нярайн хагалгааны тоног төхөөрөмж авах зардалд хөрөнгө оруулалт хийж амжилттай хүлээлгэн өгсөн.

ASPAC Улаанбаатар 2017

JCI олон улсын байгууллагын Ази Номхон Далайн бүсийн залуу манлайлагчдийн чуулган болох ASPAC арга хэмжээг ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.

Jamboree 2017

Ази Номхон далайн бүсийн Скаутын 31 дэх чуулга уулзалт “Jamboree 2017” арга хэмжээнд ивээн тэтгэгчээр хамтран ажиллав

ОУ-ын Хүүхдийн Спортын VII наадмын албан ёсны ивээн тэтгэгчээр ажиллав.

Улаанбаатар цом-2017

Боксын Олон Улсын “А” зэрэглэлийн “Улаанбаатар цом-2017” тэмцээнд АПУ Company ивээн тэтгэгчээр оролцлоо.

Бадминтоны өсвөр үе насанд хүрэгчдийн олон улсын тэмцээн

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг биеийн тамир спортын газар болон Монголын бадминтоны холбооноос зохион байгуулж буй өсвөр үе насанд хүрэгчдийн олон улсын тэмцээн энэ сарын 20-25 өдрүүдэд зохион байгуулагдаж байна. Энэхүү олон улсын бадминтоны тэмцээнийг АПУ компани ивээн тэтгэн оролцож байгаа билээ.

Ирээдүйгээ сүүгээр мялаая

Дэлхийн сүүний өдөртэй холбогдуулан Монголын Сүүний Нэгдсэн Холбоо санаачлан Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн газартай хамтарч уг өдрийг “ИРЭЭДҮЙГЭЭ СҮҮГЭЭР МЯЛААЯ” гэсэн уриан доор ХҮҮХЭД-СҮҮ-ЭРҮҮЛ МЭНД гэсэн агуулгатайгаар 2 дах удаагаа тэмдэглэж байна. Монголын Сүүний Нэгдсэн Холбооны фермерүүдийн хандивласан сүүг АПУ компанийн Сүүний үйлдвэрт үнэ төлбөргүй боловсруулан “Мааму” брендийн сүүг үйлдвэрлэн хүүхдийн баярын хөтөлбөрийн хүрээнд хүрэлцэн ирсэн 10 000 хүүхэд багачууддаа бэлэглэлээ.

Залуу мэс засалчдын анхдугаар чуулга уулзалт

Монголын залуу мэс засалчдын холбооноос “We Can Do It” уриан дор залуу мэс засалчдын анхдугаар чуулга уулзалтыг зохион байгууллаа. Бид Монгол улсын мэс заслын салбарт ажиллаж байгаа залуу мэс засалч нараа дэмжин анхдугаар чуулга уулзалтад нь хамтран ажиллалаа.

Итгэл найдвар, Боломж Улаанбаатар -2017

Жил бүр зохион байгуулагддаг “Итгэл найдвар, Боломж Улаанбаатар -2017” хандивын марафон гүйлт 3 дах жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү марафоныг Ахиллис Монгол ТББ зохион байгуулдаг бөгөөд үндсэн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор дамжуулан өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, спортоор хичээллэх, олон улсын тэмцээнд оролцоход бэлтгэх, санхүүжүүлэхэд шаардлагатай хандивыг босгох зорилготой билээ. Энэхүү үйл ажиллагаанд 600 гаруй сайн дурын ажилтан ажилласан бөгөөд АПУ компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд ивээн тэтгэн хамтран ажиллаа

FC Ulaanbaatar

Багийн спортыг Монголд хөгжүүлэх зорилгоор FC Ulaanbaatar хөл бөмбөгийн шигшээ багтай гэрээ байгуулан хамтран ажилласан.

АПУ компани гал түймэр унтраах ажиллагаанд нэгдлээ

2017 оны 7 дугаар сард манай орны нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн гал түймрийн аюулаас хүн ард, мал амьтад, хүрээлэн байгаа орчныг авран хамгаалах, учирсан хохирлыг арилгах, үйлсэд АПУ ХК-ны хамт олон сэтгэл зүрхээрээ нэгдэн, 50 сая төгрөгийн бүтээгдэхүүний тусламж үзү үлсэн билээ.



ТАЙЛАГНАЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгтгэсэн үр дүн 2017 он	
ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	сая.төг	236,018.93
Биет бус хөрөнгө	сая.төг	620.60
Биологийн хөрөнгө	сая.төг	50.46
Урт хугацаат хөрөнгө оруулалт	сая.төг	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	6,221.05
Гүүдвилл	сая.төг	217,818.52
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	сая.төг	460,729.56
Бараа материал	сая.төг	69,353.76
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	сая.төг	7,571.78
Татвар, НДШ-ийн авлага	сая.төг	2,935.42
Дансны авлага	сая.төг	30,911.50
Бусад авлага	сая.төг	10,744.99
Бусад санхүүгийн хөрөнгө	сая.төг	5.94
Бусад эргэлтийн хөрөнгө	сая.төг	212.77
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	50,448.76
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	сая.төг	172,184.92
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	632,914.48
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	сая.төг	106.30
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,094.87
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	78,756.44
Хуримтлагдсан ашиг	сая.төг	88,485.13
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	1,482.92
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	сая.төг	506,925.66
ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	сая.төг	29,763.72
Хойшлогдсон татварын өр	сая.төг	1,124.02
Бусад өглөг	сая.төг	580.20
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	31,467.94
Богино хугацаат зээл	сая.төг	39,338.47
Татварын өр	сая.төг	19,473.74
Ноогдол ашгийн өр	сая.төг	20,570.11
Бусад өглөг	сая.төг	15,138.56
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	94,520.88
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	125,988.82
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	сая.төг	632,914.48

Дэлгэрэнгүй орлогын тайлан

Нэгтгэсэн үр дүн 2017 он

Борлуулалтын орлого	234,606.13
Борлуулалтын өртөг	(164,218.13)
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	70,388.00
Борлуулалт, маркетингийн зардал	(32,495.69)
Бусад орлого	867.52
Бусад зардал	(1,952.27)
Санхүүгийн орлого	424.78
Санхүүгийн зардал	(5,528.39)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,432.11
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	(32.04)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	34,104.02
Орлогын татварын зардал	(9,232.08)
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	24,871.94
Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	1,896.80
ТАЙЛАНТ ҮЕИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	26,768.74

Өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	ХУРИМТЛАГДСАН АШИГ	БУСАД НӨӨЦ	НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	ХЯНАЛТЫН ЭРХГҮЙ ХУВЬ ОРЛОЦОО	НИЙТ ДҮН
2017 эхний үлдэгдэл	сая.төг	74.29	(0.12)	64,725.33	80,694.98	-	145,494.48
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	41.73	(41.74)	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	сая.төг	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	(5,191.69)	-	-	(5,191.69)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	2,882.67	-	-	2,882.67
2017 залруулсан	сая.төг	74.29	(0.12)	62,458.06	80,653.24	-	143,185.47
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	1,896.80	(1,896.80)	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	сая.төг	32.13	-	-	-	338,094.87	1,482.92
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	(741.67)	-	-	(741.67)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	24,871.94	-	-	24,871.94
2017 /нэгтгэсэн/	сая.төг	106.42	(0.12)	88,485.13	78,756.44	338,094.87	506,925.66

Мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгтгэсэн үр дүн 2017 он	
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	41,778.54
Бараа борлуулсны орлого	сая.төг	355,357.67
Бараа материал худалдан авахад төлсөн	сая.төг	(140,016.36)
Татвар, НД-ийн байгууллагуудад төлсөн	сая.төг	(125,632.55)
Ажиллагсдад төлсөн	сая.төг	(9,444.67)
Ашиглалтын зардалд төлсөн	сая.төг	(6,494.58)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэгт төлсөн	сая.төг	(4,321.62)
Хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(5,433.62)
Бусад мөнгөн орлого	сая.төг	4,333.20
Бусад мөнгөн зарлага	сая.төг	(26,568.93)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(3,576.14)
Мөнгөн орлого	сая.төг	1,172.30
Мөнгөн зарлага	сая.төг	(4,748.44)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	(33,606.56)
Мөнгөн орлого	сая.төг	5,785.89
Мөнгөн зарлага	сая.төг	(39,392.43)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	4,595.84
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	сая.төг	45,852.92
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	сая.төг	50,448.76

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ /MD&A/

Нэгдсэн АПУ хувьцаат компанийн анхны хувьцаа эзэмшигчийн хурал 2018 оны 01-р сарын 25-ны өдөр болж шинэ бүрэлдэхүүн бүхий Төлөөлөн Удирдах зөвлөл сонгогдсон билээ.

Шинэ бүрэлдэхүүнээр байгуулагдсан АПУ Хувьцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал 2018 оны 02-р дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан ба уг хурлаар нэгдсэн АПУ Хувьцаат Компанийн 2017 оны санхүүгийн үр дүнг гүйцэтгэл болон 2018 оны жилийн төлөвлөгөө батлагдсан.

2018 оны 02-р сарын 21-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар батлагдсан 2017 оны менежментийн тайлангийн үр дүнг нэгтгэсэн санхүүгийн тайлантай харьцуулан доор харууллаа.

- Орлого үр дүнгийн тайлан

Менежментийн тайлан			Нэгтгэсэн санхүүгийн тайлан		
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	399,060	Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	234,606
Шууд материалын өртөг	сая.төг	(171,421)	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	(164,218)
Тээврийн зардал	сая.төг	(15,644)	Бохир ашиг	сая.төг	70,388
Борлуулалт, маркетингийн зардал	сая.төг	(22,939)	Үйл ажиллагааны зардал	сая.төг	(32,496)
Бохир ашиг	сая.төг	189,056	Татвар, хүүгийн өмнөх ашиг	сая.төг	37,892
Үйл ажиллагааны зардал	сая.төг	(112,729)	Үйл ажиллагааны бус орлого, зардал	сая.төг	1,740
Татвар, хүүгийн өмнөх ашиг	сая.төг	76,327	Санхүүжилтийн зардал	сая.төг	(5,528)
Үйл ажиллагааны бус орлого, зардал	сая.төг	1,332	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	34,104
Санхүүжилтийн зардал	сая.төг	(5,559)	Орлогын албан татвар	сая.төг	(9,232)
Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	72,100	Татварын дараах ашиг, алдагдал	сая.төг	24,872
Орлогын албан татвар	сая.төг	(17,417)	Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	сая.төг	1,897
Татварын дараах ашиг, алдагдал	сая.төг	54,682	Тайлант үеийн дэлгэрэнгүй орлого	сая.төг	26,768

Тайлбар: Менежментийн тайланг бэлтгэхдээ удирдлагын шийдвэр гаргалтыг дэмжих үүднээс нэгдсэн /combined/ хэлбэрээр бэлтгэсэн бөгөөд АПУ Хувьцаат Компанийн охин компаниуд болох АПУ Трэйдинг ХХК, АПУ Дэйри ХХК, Делод ХХК, Натур Агро ХХК, Улаанбаатар спирт ХХК, Спирт Бал Бурам ХХК, М-Си-Эс Азия Пасифик Брьюери ХХК, СББ Трэйд ХХК нарын 2017 оны бүтэн жилийн үр дүнг багтаасан үзүүлэлтүүд юм.

Харин Нэгтгэсэн санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт ("СТОУС") 10 буюу "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" хэмээх стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд нэгтгэлийн өдрийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС 3")-ын дагуу нэгтгэгдэгч дахь хяналтаа бүрэн олж авсан өдрийг 2017 оны 12 сарын 31-р авч үзсэн. Тиймээс нэгтгэсэн Санхүүгийн тайланд АПУ хувьцаат компанийн дээр дурьдсан охин компаниудын үр дүнг тусгагдаагүй болно.

ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

Нэгтгэлийн өдөр

Нэгтгэлийн өдрийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС 3")-ын дагуу нэгтгэгдэгч дахь хяналтаа бүрэн олж авсан өдөр болох 2017 оны 12 сарын 22-оор тодорхойлсон. Нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа уг өдрийг 2017 оны 12 сарын 31-ээр авсан бөгөөд тухайн хугацааны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг уг тайланд мэдэгхүйц нөлөөгүй гэж үзсэн.

Тайлагналын нийцэл

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт ("СТОУС") 10 буюу "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн хэдий ч Групп компани нь нэгдсэн бүртгэлийн бодлого баримтлаагүй болно. Тиймээс хөрөнгө оруулалт, охин компаний цэвэр хөрөнгө бодит үнэ цэнээр хэмжигдээгүй.

Үнэлгээний суурь

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

Хөрөнгө оруулалт болон охин компаний эздийн өмчийг тохируулахдаа дансны үнийг ашигласан болно.

Хөрөнгө оруулалт болон охин компаний цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох хөрөнгийн дахин үнэлгээний ажил явагдаж байна.

Бүртгэлийн болон толилуулгын валют

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ХӨРӨНГӨ

Түрээсийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, эзэмшил компанид бүрэн шилжсэн гэж үзсэн тохиолдолд санхүүгийн түрээсээр ангилж, бүртгэдэг. Санхүүгийн түрээсийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэдэг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

ХУВЬЦААТ КАПИТАЛ

ЭНГИЙН ХУВЬЦАА.

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компаний үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн хугацаанд нийт түрээсийн зардлын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ v

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.





ТАЙЛБАР ТОЛЬ

Тайлант үе

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

Санхүүгийн тайлан

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

Хөрөнгө

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-Биет бус хөрөнгө

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчиддээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-Үндсэн хөрөнгө

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-Эргэлтийн бус хөрөнгө

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-Эргэлтийн хөрөнгө

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-Урьдчилж төлсөн зардал

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

Дансны Авлага

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

Бусад санхүүгийн хөрөнгө

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

Мөнгөтэй түүнтэй адилтгах хөрөнгө

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

Мөнгөн суурьт арга

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

Аккрузал суурьт арга

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

Хувьцаат капитал

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

Дахин үнэлгээний нөөц

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

Өр төлбөр

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

Урт хугацаат өр төлбөр

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

Богино хугацаат өр төлбөр

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-Орлогын тайлан

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

Борлуулалтын орлого

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

ББӨ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НА

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-Үйл ажиллагааны зардал

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦА

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

Татварын хувь хэмжээ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОАТ

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-Мөнгөн гүйлгээний тайлан

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Монгол улс, Улаанбаатар хот 17040,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 48.
Утас: 11-344837
www.apu.mn